ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ХАРЬЯА

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

# НИСЭХИЙН ЦАГ УУРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР
# ИНД-174

БАТЛАВ:

НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ТӨВИЙН ДАРГА Б.БАНЬДСҮРЭН

2022 оны 8 сарын 29 өдөр

БАТЛАВ:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН УЦУОШТ-ИЙН ДАРГА С.АЛТАНДОЛГИОН

2022 оны .....сарын ...... өдөр

ХЯНАСАН:

НЦУТ-ИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА,
ЧАНАРЫН МЕНЕЖЕР Б.БАТЦЭЦЭГ

2022 оны 8 сарын 25 өдөр

БОЛОВСРУУЛСАН:

НЦУТ-ИЙН ОРОН НУТАГ ХАРИУЦСАН
ЕРӨНХИЙ ТЕХНОЛОГИЧ ИНЖЕНЕР Н.БАСБИШ

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН УЦУОШТ-ИЙН
ЦАГ УУР, МЭДЭЭЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА Б.САЙНЖАРГАЛ

2022 оны 8 сарын 25 өдөр

# МЭДЭГДЭЛ

Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт үйлдэж буй нислэгт аюулгүй байдал хангасан уур амьсгалын мэдээгээр үйлчлэх, урьдчилсан мэдээний үйлчилгээ, мэдээлэл түгээх, зааварчилгаа өгөх, цаг уурын мэдээний болон цаг уурын ажиглалтын үйлчилгээ гэсэн үндсэн чиглэлийн дагуу Орхон аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвөөс Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ОУИНБ)-ын стандарт, Иргэний нисэхийн дүрэм 174-ийн шаардлага, “Нислэгийн цаг уурын үйлчилгээний байгууллагын ерөнхий заавар”-т нийцүүлэн Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын онцлогт тохирсон ”Үйл ажиллагааны заавар”-ыг боловсруулан, баталгаажуулан мөрдөж ажиллана.

Дархан-Уул аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдэх нислэгт ДЦУБ-ын баримт бичгүүд, Чикагогийн конвенцийн Хавсралт 3 (ANNEX-3)-т заагдсан стандарт шаардлагуудыг хангасан үйлчилгээг үзүүлнэ.

Дархан-Уул аймгийн УЦУОШТ-ийн Үйл ажиллагааны зааварт байгууллагын зохион байгуулалтын бүтэц, удирдах албан тушаалтнууд, инженер техникийн ажилтнуудын үйлчилгээний ажлын цар хүрээ, мэргэжил, ур чадвар, сургалт дадлага, хангаж байгаа цаг уурын мэдээлэл, үзүүлж байгаа цаг уурын үйлчилгээ, сүлжээ, тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны хүлээн зөвшөөрөгдөх минимум үзүүлэлт, стандарт, гүйцэтгэлийн болон чанарын минимум түвшин, түүнийг хэмжихэд шаардлагатай тестийн төхөөрөмж, систем, цаг уурын мэдээллийг гаргах шаардлагуудын талаар тусгаж, холбогдох заавар, журмуудыг боловсруулан ажиллана.

Дархан-Уул аймгийн УЦУОШТ-ийн зохион байгуулалтын бүтэц, удирдах албан тушаалтан, цаг уурын үйлчилгээний цар хүрээ, УЦУОШТ-ийн байршил болон үйлчлэх нутаг дэвсгэрийн хэмжээ өөрчлөгдөх, үйл ажиллагаатай холбоотой заавар журамд өөрчлөлт орох бол холбогдох журмын дагуу Нислэгийн цаг уурын төвд мэдэгдсэн байна.

**АГУУЛГА**

НҮҮР ХУУДАС ....................................................0
МЭДЭГДЭЛ....................................................i
АГУУЛГА....................................................ii-iii
ЕРӨНХИЙ АГУУЛГЫН ЖАГСААЛТ....................................................iv
НЭМЭЛТ БОЛОН ӨӨРЧЛӨЛТҮҮДИЙН БҮРТГЭЛ....................................................v
БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТЫН МЭДЭЭЛЭЛ....................................................vi
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР....................................................vii
А БҮЛЭГ....................................................9
1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ ....................................................9
1.1 Нисэхийн цаг уурын үйлчилгээний зорилго....................................................9
1.2 Тодорхойлолт....................................................9
Б. БҮЛЭГ ....................................................9
1. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО....................................................9
1.1 Аюулгүй байдлын бодлого....................................................9
1.2 Аюулгүй байдлын зорилго....................................................9
1.3 Аюулгүй байдлын зорилт....................................................9
1.4 Аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн ерөнхий төлөвлөгөө....................................................9
1.5 Аюулгүй байдлын баталгаажуулалт ....................................................9
В. БҮЛЭГ....................................................11
1. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН НЭРС, АЛБАН ТУШААЛ ....................................................11
1.1 УЦУОШТ-ийн үйл ажиллагааг дүрмийн дагуу явагдаж байгааг бататгах үүрэг бүхий албан тушаалтнууд: ....................................................11
1.2 Удирдах албан тушаалтнуудын үүрэг, хариуцлага: ....................................................11
1.3 Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн зохион байгуулалтын бүтцийн дэлгэрэнгүй....................................................12
1.4 Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн байрлал....................................................13
1.5 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын цаг уурын үйлчилгээ, үйлчилгээнд хамрагдах нутаг дэвсгэр, агаарын зай....................................................13
1.6 Албан хаагчдын ур чадвар, мэргэжлийн түвшин....................................................13
1.7 Нисэхийн цаг уурын үйлчилгээний зохион байгуулалт....................................................13
1.8 Нисэхийн цаг уурын үйлчилгээ үзүүлэх албан хаагчдын эрх, үүрэг....................................................14
1.9 Баримт бичгийн хөтлөлт ....................................................14
2. ИНД174.103. (1) ХАНГАЖ БАЙГАА ЦАГ УУРЫН МЭДЭЭЛЭЛ БОЛОН ҮЗҮҮЛЖ БАЙГАА ҮЙЛЧИЛГЭЭ....................................................15
2.1 Хангаж байгаа цаг уурын мэдээлэл ....................................................15
2.2 Цаг уурын мэдээний стандарт болон формат....................................................15
2.3 Үзүүлж байгаа цаг уурын үйлчилгээ....................................................16
3. ИНД174.103. (4) БОЛОВСРУУЛАН ГАРГАХ ЦАГ УУРЫН МЭДЭЭЛЭЛ, ХАНГАЖ БАЙГАА ЦАГ УУРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН БОЛОН ЧАНАРЫН МИНИМУМ ТҮВШИН ....................................................16
3.1 Боловсруулан гаргах цаг уурын мэдээний чанарын минимум түвшин ....................................................16
3.2 Цаг уурын мэдээний өгөгдөл цуглуулах....................................................18
3.3 Мэдээ, мэдээллийг түгээх, дамжуулах....................................................18
3.4 Мэдээг бичих бүдүүвч болон дамжуулах цагийн хуваарийг чанд баримтална ....................................................19
4. ИНД174.103. (5) СҮЛЖЭЭ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ....................................................19
4.1 Сүлжээ, тоног төхөөрөмж....................................................19
4.2 Бататгах, хугацаат үзлэг шалгалт, тест тохируулга хийх ....................................................20

4.3 Осол, эсхүл зөрчлийн дараа цаг уурын мэдээллийг шалгах ........................ 20
4.4 Алдаатай мэдээлэл ........................ 20
4.5 Бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, арчлах болон устгах ........................ 20
5. ИНД174.103. (6) ЦАГ УУРЫН МЭДЭЭЛЛИЙГ ГАРГАХАД ЗААВАЛ МӨРДӨХ ШААРДЛАГАТАЙ ШАЛГАЛТЫН ЖУРАМ ........................ 20
5.1 Цаг агаарын бодит болон урьдчилсан мэдээг гаргах ........................ 20
6. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗААВРЫГ ХЯНАХ, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БОЛОН ТҮГЭЭХ ........................ 21
6.1 Хяналт тавих ........................ 21
6.2 Нэмэлт, өөрчлөлт оруулах ........................ 21
6.3 Түгээх ........................ 21

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө
Зураг.2 Бүтцийн дэлгэрэнгүй

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Удирдах ажилтнуудын нэрс
Хүснэгт 2. Удирдах ажилтнуудын үүрэг хариуцлагын тодорхойлолт
Хүснэгт 3. Хаяг байршил
Хүснэгт 4. Үйлчилгээний төрөл, нутаг дэвсгэр, агаарын зай
Хүснэгт 5. OPMET мэдээг солилцох схем
Хүснэгт 6. TAF мэдээнд орох тоон элементүүдийн хязгаарын утга ба нарийвчлал
Хүснэгт 7. Урьдчилсан мэдээний чанарын минимум түвшин
Хүснэгт 8. Мэдээ дамжуулах хуваарь

ЖУРМЫН ЖАГСААЛТ

Журам 1. Осол, эсхүл зөрчлийн дараа цаг уурын мэдээллийг шалгах журам
Журам 2. Эрсдэлийг үнэлэх журам
Журам 3. Дотоод аудитын журам
Журам 4. Аюулгүй байдлын удирдлагын журам
Журам 5. Сургалтын журам
Журам 6. Нислэгийн цаг уурын мэргэшлийн үнэмлэх олгох журам
Журам 7. Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын инженер, техникчдэд мэргэшлийн зэрэг, ур чадварын нэмэгдэл олгох журам
Журам 8. Үл тохирох бүтээгдэхүүний хяналтын журам
Журам 9. Залруулах арга хэмжээний журам
Журам 10. Нислэгийн цаг агаарын таараагүй мэдээнд дүн шинжилгээ хийх журам

ЗААВРЫН ЖАГСААЛТ

Заавар 1. Нислэгийн цаг уурын мэдээ дамжуулах ашиглалтын заавар

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1. Албан тушаалын тодорхойлолт
Хавсралт 2. Хөтлөгдөх баримт бичгийн жагсаалт

НИСЛЭГТ ЦАГ АГААРЫН МЭДЭЭГЭЭР ҮЙЛЧЛЭХ, МЭДЭЭГ ХЭРЭГЛЭХ ТАЛААР ХАМТРАН АЖИЛЛАХ ЕРӨНХИЙ ГЭРЭЭ

# ЕРӨНХИЙ АГУУЛГЫН ЖАГСААЛТ


| № | Хэсэг | Хуудас | Хэвлэл, өөрчлөлт | Огноо |
|---|---|---|---|---|
| 1 | АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО | 9 | Хэвлэл 2 | 2022.08.25 |
| 2 | ДАРХАН-УУЛ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН НЭРС, АЛБАН ТУШААЛ | 11 | Хэвлэл 2 | 2022.08.25 |
| 3 | ХАНГАЖ БАЙГАА ЦАГ УУРЫН МЭДЭЭЛЭЛ БОЛОН ҮЗҮҮЛЖ БАЙГАА ҮЙЛЧИЛГЭЭ | 15 | Хэвлэл 2 | 2022.08.25 |
| 4 | БОЛОВСРУУЛАН ГАРГАХ ЦАГ УУРЫН МЭДЭЭЛЭЛ, ХАНГАЖ БАЙГАА ЦАГ УУРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН БОЛОН ЧАНАРЫН МИНИМУМ ТҮВШИН | 16 | Хэвлэл 2 | 2022.08.25 |
| 5 | СҮЛЖЭЭ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ | 19 | Хэвлэл 2 | 2022.08.25 |
| 6 | ЦАГ УУРЫН МЭДЭЭЛЛИЙГ ГАРГАХАД ЗААВАЛ МӨРДӨХ ШААРДЛАГАТАЙ ШАЛГАЛТЫН ЖУРАМ | 21 | Хэвлэл 2 | 2022.08.25 |
| 7 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗААВРЫГ ХЯНАХ, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БОЛОН ТҮГЭЭХ | 21 | Хэвлэл 2 | 2022.08.25 |

## НЭМЭЛТ БОЛОН ӨӨРЧЛӨЛТҮҮДИЙН БҮРТГЭЛ

| № | Өөрчлөлт /Change number / | Өөрчлөлт оруулсан огноо /Inserted date / | Тайлбар / Comments / | Гарын үсэг /Signature / |
|---|---|---|---|---|
| 1 | Хэвлэл 1 | 2020.05.14 | Анхны хэвлэл | Б.Сайнжаргал Н.Басбиш |
| 2 | Хэвлэл 2 | 2022.08.25 | Шинэчлэгдэн батлагдсан ИНД 174 дүрэмтэй холбоотой “Нислэгийн цаг уурын үйлчилгээний байгууллагын ерөнхий заавар”-ыг боловсруулж баталгаажуулсан тул үйл ажиллагааны зааварт шинэчлэлт хийгдсэн. | Б.Сайнжаргал Н.Басбиш |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

## БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

| **№** | ***Хэлтэс, алба***<br>*Division name* | ***Хяналтын дугаар*** | ***Хувь***<br>*Version* | ***Гарын үсэг***<br>*Signature* |
|---|---|---|---|---|
| 1 | Дархан-Уул аймгийн УЦУОШТ | 01 | 1 | |
| 2 | НЦУТ-ийн Аюулгүй ажиллагаа, чанарын хяналтын хэсэг | 02 | 1 | |
| 3 | ИНЕГ-ын Нислэгийн аюулгүй ажиллагааны, хяналт зохицуулалтын алба | 03 | 1 | |
| | ***Нийт*** | | 3 | |

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| ААЧХХ | - Аюулгүй ажиллагаа, чанарын хяналтын хэсэг |
| ДЦУБ | - Дэлхийн цаг уурын байгууллага |
| ИНД | - Иргэний нисэхийн дүрэм |
| ИНБД | - Иргэний нисэхийн багц дүрэм |
| ИНЕГ | - Иргэний нисэхийн ерөнхий газар |
| НААХЗА | - Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба |
| НЦУТ | - Нислэгийн цаг уурын төв |
| НЦУҮБ | - Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага (төв, орон нутгийн) |
| ОУДЦ | - Олон улсын дундаж цаг |
| ОУИНБ | - Олон улсын иргэний нисэхийн байгууллага |
| УЦУОСМХ | - Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн |
| УЦУОШТ | - Ус цаг уур, орчны шинжилгээний төв |
| ЦУОШГ | - Цаг уур, орчны шинжилгээний газар |
| ЦУМҮХ | - Цаг уур, мэдээлэл үйлчилгээний хэлтэс |

# А БҮЛЭГ

## 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

### 1.1 Нисэхийн цаг уурын үйлчилгээний зорилго

Нислэгт аюулгүй байдал хангасан цаг агаарын мэдээ, мэдээллээр шуурхай үйлчлэх

### 1.2 Тодорхойлолт

**Цаг агаарын үндсэн мэдээ** / Basic weather report гэж нисэхийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор тодорхой газар нутаг, эсхүл агаарын зайд ажиглагдсан дараах цаг агаарын бодит нөхцөлийг тодорхойлж байгаа аман мэдээллийг:

a) салхины чиглэл ба хүч;
b) далайн дундаж түвшний агаарын даралт;
c) агаарын хэм;
d) цаг агаарын нөхцөл болон үүлшил;

**Цаг уурын алба** / Meteorological office гэж цаг уурын үйлчилгээгээр хангадаг, эсхүл дэмжлэг үзүүлдэг албыг, эсхүл цаг уурын мэдээллийг нэгтгэдэг, боловсруулдаг, эсхүл хэрэглэгчдэд дамжуулдаг албыг;

**Цаг уурын алдаатай мэдээлэл** / Erroneous meteorological information гэж тухайн мэдээний зөвшөөрөгдөхүйц нарийвчлал, эсхүл зөвшөөрөгдөх хэмжээнээс ихээхэн хэмжээгээр хэтэрсэн, эсхүл хэтэрсэн байж болох цаг уурын мэдээллийг;

**Цаг уурын мэдээ** / Meteorological report гэж нисэхийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор, тодорхой цаг болон байрлалтай холбоотой ажиглагдсан цаг уурын нөхцөлийн мэдэгдлийг;

**Цаг уурын мэдээлэл** / Meteorological information гэж нисэхийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх цаг уурын мэдээ, дүн шинжилгээ, эсхүл урьдчилсан мэдээ болон одоогийн, эсхүл таамаглаж байгаа цаг уурын нөхцөлтэй холбоотой нисэхийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бусад мэдэгдлийг;

**Цаг уурын үйлчилгээ** / Meteorological service гэж нисэхийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор цаг уурын мэдээллээр хангадаг дараах үйлчилгээг:

a) *Уур амьсгалын мэдээний үйлчилгээ (C):* тодорхой газар нутаг, эсхүл агаарын зайд зориулан уур амьсгалын мэдээ боловсруулах болон хангах үйлчилгээ;
b) Урьдчилан мэдээлэх үйлчилгээ *(F):* тодорхой газар нутаг, эсхүл агаарын зайн хэсэгт зориулан цаг уурын урьдчилсан мэдээллээр хангах үйлчилгээ;
c) *Мэдээлэл түгээх үйлчилгээ (D):* цаг уурын мэдээллийг цуглуулах болон түгээх үйлчилгээ;
d) *Цаг уурын мэдээний зааварчилгаа өгөх үйлчилгээ (B):* цаг уурын одоогийн болон таамаглаж байгаа нөхцөлийг бичгээр болон амаар тайлбарлан мэдээлэх үйлчилгээ;
e) *Цаг уурын мэдээний үйлчилгээ (R):* цаг уурын тогтмол мэдээгээр хангах үйлчилгээ;
f) *Цаг уурын ажиглалтын үйлчилгээ (W):* тодорхой газар нутаг дахь агаарын хөлгийн үйл ажиллагаанд нөлөөлөх цаг уурын нөхцөлд ажиглалт хийх үйлчилгээ;

Энэхүү зааврыг ИНД-174 дүрмийн “Үйл ажиллагааны зааварт тавигдах шаардлага”-ын дагуу боловсруулсан бөгөөд Дархан-Уул аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв (УЦУОШТ)-ийн нисэхийн цаг уурын үйлчилгээ үзүүлж буй албан хаагчид дагаж мөрдөнө.

# Б. БҮЛЭГ

## 1. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

### 1.1 Аюулгүй байдлын бодлого

Агаарын навигацийн үйл ажиллагаанд аюулгүй байдал хангасан цаг уурын мэдээ, мэдээллээр тасралтгүй, шуурхай үйлчилнэ.

### 1.2 Аюулгүй байдлын зорилго

Аюулгүй байдлын хүлээн зөвшөөрөгдөх түвшинг Монгол Улсын хууль тогтоомж, Дэлхийн цаг уурын байгууллагын (ДЦУБ) болон Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ОУИНБ)-ын баримт бичиг, Иргэний нисэхийн багц дүрэм (ИНБД)-ийн шаардлагад нийцүүлэн тодорхойлж, үйл ажиллагааг байнга сайжруулснаар олон улсын стандартад хүрсэн Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлнэ.

### 1.3 Аюулгүй байдлын зорилт

Аюулгүй байдлын ач холбогдлыг албан хаагч бүрт ухамсарлуулах, зөв дадал, аюулгүй байдлын удирдлагын соёлыг хэвшүүлэх үүднээс болзошгүй аюул, осол зөрчлийн тухай мэдээллийг нээлттэй, шуурхай авдаг, шийтгэлгүй мэдээллийн системийг бий болгоно. Үүнд хувь хүн бүрийн оролцоог идэвхжүүлэх урамшууллын тогтолцоог бүрдүүлэн ажиллана.

### 1.4 Аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн ерөнхий төлөвлөгөө




Зураг 1. Аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө

### 1.5 Аюулгүй байдлын баталгаажуулалт

1.5.1 Нисэхийн аюулгүй байдалд учрах аюулыг олж тогтоох, холбогдох эрсдэлийг үнэлэх болон удирдах эрсдэлийн удирдлагын үйл явцыг Нислэгийн цаг уурын төв (НЦУТ)-ийн даргын 2021 оны А/11 дүгээр тушаалаар баталсан “Эрсдэлийн үнэлгээг хийх журам”-аар зохицуулна.

1.5.2 Нислэгийн осол, зөрчил, саатлыг НЦУТ-ийн ээлжийн синоптик инженер 71287279, 71287419, 91287279, 71283039, Аюулгүй ажиллагаа, чанарын менежерийн 71283053 дугаарын утсаар мэдэгдэнэ. Түүнд дүн шинжилгээ хийх үйл явцыг НЦУТ-ийн даргын 2021 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан “Осол, эсхүл зөрчлийн дараа цаг уурын мэдээллийг шалгах журам”, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг НЦУТ-ийн даргын 2021 оны А/11 дүгээр тушаалаар батлагдсан “Эрсдэлийн үнэлгээг хийх журам”-аар тус тус зохицуулна.

1.5.3 Дотоод аудит хийх болон Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоонд тогтмол дүгнэлт хийх ажиллагааг НЦУТ-ийн даргын 2021 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын журам”, 2022 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан “Аюулгүй байдлын удирдлагын журам”-аар тус тус зохицуулна.

1.5.4 Албан хаагчдыг Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх, ур чадварыг дээшлүүлэх, бататгах сургалтад хамруулж, үнэмлэхжүүлнэ.

# В. БҮЛЭГ

## 1. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН НЭРС, АЛБАН ТУШААЛ

Цаг уурын үйлчилгээ бүрийг санхүүжүүлэх, ИНД-174 дүрэмд заасан шаардлага болон стандартын дагуу гүйцэтгэгдэж байгааг бататгах үүрэг бүхий Гүйцэтгэх захирал (цаашид төвийн дарга гэх)-ын албан тушаалд томилогдсон удирдах ажилтан:

Дархан-Уул аймгийн УЦУОШТ-ийн үйл ажиллагаа нь нисэхийн цаг уурын үйлчилгээний үйл ажиллагааны зааврын дагуу гүйцэтгэгдэж, санхүүжиж байгааг хянах, ИНД-174-ийн биелэлтэд хяналт тавих, Цаг уур, орчны шинжилгээний газар (ЦУОШГ) болон НЦУТ-ийн удирдах албан тушаалтантай шууд харьцаж илтгэх эрх бүхий удирдах албан тушаалтан:

С.Алтандолгион: Дархан-Уул аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга

### 1.1 УЦУОШТ-ийн үйл ажиллагааг дүрмийн дагуу явагдаж байгааг бататгах үүрэг бүхий албан тушаалтнууд:

Хүснэгт 1. Удирдах ажилтнуудын нэрс

| № | нэр | Албан тушаал |
|---|---|---|
| 1 | С.Алтандолгион | Дархан-Уул аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга |
| 2 | Б.Сайнжаргал | Цаг уур, мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга |

### 1.2 Удирдах албан тушаалтнуудын үүрэг, хариуцлага:

Хүснэгт 2. Удирдах ажилтнуудын үүрэг хариуцлагын тодорхойлолт

| Албан тушаал | Үүрэг, хариуцлага |
|---|---|
| УЦУОШТ-ийн дарга | - Энэхүү зааварт нийцүүлэн зохион байгуулахад шаардлагатай төсвийн төлөвлөгөөг ЦУОШГ-т хүргүүлж батлуулах<br>- УЦУОШТ-ийн нислэгт цаг уурын мэдээ мэдээллээр үйлчилж буй албан хаагчдыг зохих хууль дүрэм, эрх зүйн баримт бичгийн хүрээнд удирдан зохион байгуулах<br>- УЦУОШТ-ийн үйл ажиллагааг Монгол улсын Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Иргэний нисэхийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, ДЦУБ болон ОУИНБ-ын зөвлөмж, шаардлага, ИНД-ийн нэр томьёоны тайлбар, ИНД-174, ИНД-100, AC174-1 зөвлөмжийн цувралын дагуу нисэхийн аюулгүй байдлыг хангасан цаг агаарын мэдээ мэдээллээр шуурхай хангахад чиглүүлэх, нисэхийн цаг агаарын мэдээний үйлчилгээний ажлын талаар гаргах шийдвэр, дүрэм, журам, зааврыг дангаараа буюу бусад байгууллагатай хамтран боловсруулж, холбогдох байгууллагуудаар батлуулан тэдгээрийг хэрэгжүүлэх, арга зүйн удирдлагаар хангах<br>- Нислэгийг цаг агаарын мэдээ, мэдээллээр үйлчлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахын тулд хангалттай тооны чадварлаг, мэргэшсэн боловсон хүчнийг ажиллуулах<br>- Бусад мэргэжлийн болон хэрэглэгч байгууллагуудтай хамтран ажиллах |

| | |
|---|---|
| | - УЦУОШТ-ийн Чанарын удирдлагын тогтолцоо, Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хариуцан, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, урамшууллын системийг бий болгох |
| Цаг уур, мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга | - Монгол улсын Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Иргэний нисэхийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, ДЦУБ болон ОУИНБ-ын зөвлөмж, шаардлага, ИНД-174, ИНД-100, АС174-1 зөвлөмжийн цувралын дагуу нисэхийн аюулгүй байдлыг хангасан цаг агаарын мэдээ мэдээллээр үйлчлэх, шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллах<br>- Хэлтсийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, сайжруулах, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, арга боловсруулах ажлыг зохион байгуулах, үйлчилгээний ажлын шуурхай, тасралтгүй ажиллагааг хангах, саналаа удирдлагад тавьж шийдвэрлүүлэх<br>- Нисэхийн цаг уурын мэдээний ажлын төлөвлөгөө, сургалтын хөтөлбөр боловсруулж УЦУОШТ-ийн даргаар батлуулж, биелэлтийг хanган ажиллах<br>- Чанарын удирдлагын тогтолцоо, Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх, түүнтэй холбоотой үйл ажиллагааны үл тохирлыг залруулах, дахин давтагдахгүй байх арга хэмжээг зохион байгуулах<br>- УЦУОШТ-ийн даргын эзгүйд байгууллагыг төлөөлөн харилцагч байгууллагуудтай харьцана |

## 1.3 Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн зохион байгуулалтын бүтцийн дэлгэрэнгүй




Зураг 2. Бүтцийн дэлгэрэнгүй

## 1.4 Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн байрлал

Хүснэгт 3. Хаяг байршил

| № | Байгуул-лагын нэр | Регистер | Нэгж | Хаяг | Холбоо барих утас |
|---|---|---|---|---|---|
| 1 | Дархан-Уул аймгийн УЦУОШТ | 9023291 | Цаг уур, мэдээлэл үйлчилгээний хэлтэс | Дархан-Уул аймаг, Дархан сум, 5-р баг | 70373783 |

## 1.5 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын цаг уурын үйлчилгээ, үйлчилгээнд хамрагдах нутаг дэвсгэр, агаарын зай

Хүснэгт 4. Үйлчилгээний төрөл, нутаг дэвсгэр, агаарын зай

| № | Байгууллагын нэр | Нисэхийн цаг уурын үйл ажиллагааны төрөл | | Үйлчилгээнд хамрагдах нутаг дэвсгэр | Агаарын зай |
|---|---|---|---|---|---|
| 1 | Дархан-Уул аймгийн УЦУОШТ | 4 | F(ТОЙМ), D, B, W | Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэр | - |

## 1.6 Албан хаагчдын ур чадвар, мэргэжлийн түвшин

1.6.1 УЦУОШТ-ийн нисэхийн цаг уурын үйлчилгээ үзүүлэх албан хаагчид нь тухайн албан тушаалд тохирох мэргэжлийн чиглэлээр их, дээд сургууль төгссөн, тухайн албан тушаалын тодорхойлолтод нийцсэн байна.

1.6.2 Цаг уурын мэдээ боловсруулан үйлчилгээнд гаргах, ашиглах тоног төхөөрөмжийг хариуцан ажиллах албан хаагчдын ур чадвар, мэргэжлийн түвшинг ДЦУБ-ын цуврал №1083 “Ус, цаг уурын боловсрол, сургалтын стандартыг хэрэгжүүлэх заавар”, №1209 “ДЦУБ-ын боловсон хүчний мэдлэг, ур чадварын хураангуй”, ОУИНБ-ын цуврал №10 “Цаг уурын боловсон хүчний ур чадвар, мэргэшил”, НЦУТ-ийн 2022 оны А/01 дүгээр тушаалаар баталсан “Сургалтын журам” зэрэг баримт бичигт тусгагдсан шаардлагыг хангасан байна.

1.6.3 Нисэхийн цаг уурын үйлчилгээ үзүүлэх албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг ажлын байр болон албан тушаал тус бүрээр боловсруулж, УЦУОШТ-ийн даргаар баталгаажуулсан байна. УЦУОШТ-ийн даргын албан тушаалын тодорхойлолтыг ЦУОШГ-ын дарга баталгаажуулна.

1.6.4 Цаг уурын мэдээ боловсруулан үйлчилгээнд гаргах, түүнд хяналт тавих албан хаагчдыг ЦУОШГ-ын даргын 2014 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Нислэгийн цаг уурын мэргэшлийн үнэмлэх олгох журам” -ын дагуу үнэмлэхжүүлнэ.

1.6.5 Мэргэжлийн ур чадварыг Байгаль орчны сайд, Хүн амын бодлого хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 22/38/68 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын инженер, техникчдэд мэргэшлийн зэрэг, ур чадварын нэмэгдэл олгох журам”-ын дагуу тогтооно.

1.7.6 Эрх бүхий этгээдийн мэргэжлийн ур чадварыг хадгалахдаа өмнө олж авсан мэдлэг, ур чадвараа сэргээх, түвшинг тогтоох, мэргэжлийг дээшлүүлэх, шинэ техник технологийг эзэмшихэд чиглэх, шинэ хэмжилт тохируулгын аргачлалыг сурах зэрэг чиглэлээр давтан сургалтад хамрагдаж, ажиллах эрхээ сунгасан байна.

## 1.7 Нисэхийн цаг уурын үйлчилгээний зохион байгуулалт

1.7.1 Нисэх баг, нисэхийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд оролцогч хэрэглэгч байгууллагуудыг нисэхийн аюулгүй байдал хангасан цаг агаарын төрөл бүрийн

урьдчилсан мэдээ, мэдээллээр шуурхай үйлчлэх, УЦУОШТ-ийн өдөр тутмын үйл ажиллагаа, шинжилгээ, мэдээлэл үйлчилгээ, сүлжээ, программ хангамжийн хэвийн тасралтгүй байдлыг хангаж ажиллана.

1.7.2 Нисэхийн цаг уурын үйлчилгээг ЦУМҮХ (Цаг уур, мэдээлэл үйлчилгээний хэлтэс)-ийн дарга, урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич гэсэн албан хаагчид үзүүлнэ. Үйлчилгээ үзүүлэх албан хаагчдын Албан тушаалын тодорхойлолтыг Хавсралт 1-д оруулсан.

## 1.8 Нисэхийн цаг уурын үйлчилгээ үзүүлэх албан хаагчдын эрх, үүрэг

1.8.1 Дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

a) Цаг уурын нөхцөл байдлыг үнэлэхэд шаардагдах зураг мэдээ гараагүй, сүлжээ тасарсан, бодит мэдээний хангалт байхгүй аэродром (хээрийн, түр г.м)-д бууж нислэг үйлдэх тохиолдолд, цаг уурын автомат станцын ажиглалтын аль нэг мэдрүүрт гэмтэл доголдол гарснаас ажиглалтын мэдээ бүрэн бус үед тоймчилсон (ТОЙМ) урьдчилсан мэдээгээр үйлчлэх
b) Интернэт болон сүлжээ тасарсан үед утсан холбоог ашиглах
c) Ажлын байрны нөхцөлийг сайжруулах, тоног төхөөрөмж, үйл ажиллагааг боловсронгуй болгох асуудлаар санал боловсруулан шийдвэрлүүлэх
d) Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмаар олгогдсон бусад эрх

1.8.2 Дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

a) Ус, Цаг уур орчны хяналт шинжилгээний тухай хууль, Иргэний нисэхийн тухай Монгол улсын хууль, ИНД-174, ИНД-100, АС174-1, НЦУТ-ийн дүрэм, Нисэхийн цаг уурын үйлчилгээтэй холбогдолтой журам, заавар, ажлын технологи, шаардлагад нийцсэн, нисэхийн аюулгүй байдлыг хангасан цаг уурын төрөл бүрийн бодит болон урьдчилсан мэдээ, мэдээллээр хэрэглэгч байгууллагуудыг шуурхай үйлчлэх
b) УЦУОШТ-ийн ЦУМҮХ-ийн дарга, урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич нь цаг уурын сүлжээ (GTS), интернэтэд суурилсан “Нислэгийн цаг уурын мэдээ дамжуулах ашиглалтын заавар”-ын дагуу мэдээ дамжуулах системээр (МДС) цаг агаарын урьдчилсан мэдээг дамжуулах
c) Сүлжээ, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах
d) Нисэхийн цаг уурын урьдчилсан мэдээний чанар, таарцыг дээшлүүлэхтэй холбогдсон судалгаа, шинжилгээний ажил хийх, дэвшилтэт арга технологийг мэдээллийн ажилд ашиглах, шинэчлэх

## 1.9 Баримт бичгийн хөтлөлт

1.9.1 Нисэхийн цаг уурын үйлчилгээнд дараах баримт бичгүүдийг ЦУОШГ-ын даргын 2020 оны А/51 дүгээр тушаалаар баталсан загварын дагуу хөтөлж, хадгална. Үүнд:

a) Буудал орчмын богино хугацааны ТОЙМ урьдчилсан мэдээний хуудас НИ-2
b) Районы урьдчилсан мэдээний хуудас НИ-2
c) Угталтын урьдчилсан мэдээний хуудас НИ-2
d) Чиглэлийн урьдчилсан мэдээний хуудас НИ-5
e) Агаарын хөлгийн цаг агаарын ажиглалтын хуудас
f) Хяналт, шалгалт хийх хуудас
g) Нислэгийн саатлын бүртгэлийн хуудас
h) Осол зөрчлийг мэдээлэх хуудас
i) Ээлж хүлээлцэх дэвтэр (Цаг агаарын зураг мэдээний ирц, сүлжээ, тоног төхөөрөмж, нислэгийн тоо, үйлчилсэн болон дамжуулсан мэдээний тоо, цаг агаарын зөвлөгөө)

1.9.2 Нисэхийн үйлчилгээний үйл ажиллагаанд хөтлөгдөх баримт бичгүүдийн маягтыг Хавсралт 2-д үзүүлэв.

## 2. ИНД174.103. (1) ХАНГАЖ БАЙГАА ЦАГ УУРЫН МЭДЭЭЛЭЛ БОЛОН ҮЗҮҮЛЖ БАЙГАА ҮЙЛЧИЛГЭЭ

### 2.1 Хангаж байгаа цаг уурын мэдээлэл

**Цаг агаарын бодит мэдээ (METAR, SPECI**) - Нислэгийн үйл ажиллагааг цаг уурын мэдээгээр хангах зорилгоор тусгайлсан талбай, эсхүл агаарын зайн тодорхой хэсэгт хийсэн цаг агаарын үзэгдэл элементийн ажиглалтын мэдээ

**Аэродромын урьдчилсан мэдээ (TAF)** - Аэродром дээр тодорхой хугацааны турш цаг уурын нөхцөл байдлын ирээдүйн төлөв байдлын тухай мэдээ

**AIRMET мэдээлэл (AIRMET information)** - Зөвхөн нам өндрийн нислэгт зориулсан нислэгийн замын дагуух цаг агаарын үзэгдэл, элементүүд ба тэдгээрийн цаг хугацаа, орон зайн өөрчлөлтийн тухай мэдээлэл

**Аэродромын сэрэмжлүүлэг мэдээ (Aerodrome warning)** - Зогсоол дээр байгаа агаарын хөлөг болон аэродромын байгууламж үйлчилгээнд сөрөг нөлөө үзүүлж болох цаг агаарын нөхцөл байдлын тухай товч мэдээ

**Агаарын хөлгийн ажиглалтын (Aircraft observation)** - Нисч буй агаарын хөлгөөс хийсэн цаг уурын нэг буюу хэд хэдэн элементийн ажиглалт

**Суултын урьдчилсан мэдээ (Landing forecast)** - Тухайн аэродром дээрх цаг уурын нөхцөл байдалд үүсч бий болох онцгой өөрчлөлтийн тухай товч мэдээлэл

**Хөөрөлтийн урьдчилсан мэдээ (Take-off forecast)** - Хөөрч, буух зурвас дээр тодорхой хугацааны турш бий болох урьдчилсан мэдээ

**Нам өндрийн нислэгт зориулсан районы урьдчилсан мэдээ (Area forecast for low level flights)** - Аэродромоос 50 км-ийн радиус доторх нам өндрийн нислэгт зориулсан урьдчилсан мэдээ

**Чиглэлийн урьдчилсан мэдээ (Route forecast)** - Аэродромоос нисэн гарах агаарын хөлөгт зориулсан урьдчилсан мэдээ

**Өндрийн салхины урьдчилсан мэдээ (Upper wind forecast)** - Нислэгийн мэдээллийн буюу удирдлагын бүсэд зориулсан урьдчилсан мэдээ

**Угталтын урьдчилсан мэдээ (En-route forecast)** - Урьдчилан мэдээлэх албагүй газраас ирэх нислэгт зориулсан нислэгийн замын дагуух цаг агаарын байдлын тухай урьдчилсан мэдээ

### 2.2 Цаг уурын мэдээний стандарт болон формат

Цаг уурын мэдээний стандарт болон формат нь ДЦУБ-ын цуврал №306 “Кодын гарын авлага” I боть, Чикагогийн конвенцийн Хавсралт 3 (ANNEX-3), ОУИНБ-ын Ази номхан далайн бүсийн мэдээлэл солилцооны гарын авлага (ROBEX HANDBOOK), “Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах журам” 1, 2 дугаар дэвтэрт тусгагдсан болно.

Хүснэгт 5. “ОРМЕТ” мэдээг солилцох схем

| Мэдээний төрөл | | Схем |
|---|---|---|
| Аэродромын урьдчилсан мэдээ | TAF мэдээ (9 цаг) | FCMO31 ZMDU ddhhmm (BBB)<br>TAF TOIM ZMDARKHAN-UUL ddhhmm |
| Агаарын хөлгийн ажиглалтын мэдээ | Нислэгийн явц дахь цаг агаарын аюултай үзэгдэл | UAMO61 ZMDARKHAN-UUL ddhhmm (BBB) |

*Тайлбар: dd - мэдээ дамжуулсан өдөр, hh - дамжуулсан цаг (ОУДЦ), mm – минут*

### 2.3 Үзүүлж байгаа цаг уурын үйлчилгээ

ДЦУБ-ын "Кодын гарын авлага" I боть (FM15-XV METAR, FM 16-XV SPECI, FM 51-XV TAF), ОУИНБ-ын Чикагогийн конвенцийн Хавсралт 3 (ANNEX-3)-ын шаардлагыг хангасан цаг агаарын төрөл бүрийн урьдчилсан болон бодит мэдээ, мэдээллээр шуурхай үйлчилнэ. Үүнд:

#### 2.3.1 Forecast service (F) - Урьдчилан мэдээлэх үйлчилгээ

- Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдэж буй нислэгт ДЦУБ-ын "Кодын гарын авлага" I боть (FM 51-XV TAF), "Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах журам" 1 дүгээр дэвтрийн бүлэг 6 нэмэлт 4-д тусгасан стандартын дагуу мэдээгээр үйлчлэх
- Цаг уурын нөхцөл байдлыг үнэлэхэд шаардагдах зураг мэдээ гараагүй, сүлжээ тасарсан, бодит мэдээний хангалт байхгүй аэродром (хээрийн, түр г.м)-д бууж нислэг үйлдэх тохиолдолд, цаг уурын автомат станцын ажиглалтын аль нэг мэдрүүрт гэмтэл доголдол гарснаас ажиглалтын мэдээ бүрэн бус үед тоймчилсон (ТОЙМ) урьдчилсан мэдээгээр үйлчлэх
- Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт үйлдэж буй нислэгт район, чиглэл, угталтын урьдчилсан мэдээгээр үйлчлэх
- Шаардлагатай үед Дархан-Уул аймгийн цаг агаарын урьдчилсан төлөв гаргаж өгөх

#### 2.3.2 Information dissemination service (D) – Мэдээлэл түгээх үйлчилгээ

- Орон нутгийн нислэгт шаардлагатай цаг агаарын зураг, нислэгийн төрөл бүрийн мэдээ, мэдээллийг боловсруулан гаргах, олж авах
- ОУИНБ-ын Ази номхан далайн бүсийн мэдээлэл солилцооны гарын авлага (ROBEX HANDBOOK)-ын дагуу мэдээ, мэдээллийг хүлээн авч, түгээнэ.
- Нислэгт зориулсан цаг агаарын мэдээ, мэдээллийг НЦУТ-ийн цахим хуудас, НЦУҮБ болон олон улсын цаг уурын үндэсний төвүүдээс тухай бүрт нь авч хэрэглэгчдэд түгээх
- Нислэгт шаардлагатай цаг агаарын зураг, цаг агаарын бодит болон урьдчилсан мэдээ, мэдээллийг интернэт, цаг уурын сүлжээ, телефон утсаар шуурхай дамжуулах, цуглуулах

#### 2.3.3 Meteorological briefing service (B) - Цаг уурын мэдээний зааварчилгаа өгөх үйлчилгээ

- Зурган мэдээллээр - Өндрийн салхи, температур, даралтын орны, хур тунадас, үүлшил, онцгой үзэгдлийн зургууд
- Цахим үйлчилгээ - Цаг уурын бодит болон урьдчилсан мэдээ, мэдээллийг НЦУТ-ийн цахим хуудсанд байршуулан хэрэглэгч байгууллагуудад хүргэх

#### 2.3.4 Meteorological watch service (W) – Цаг уурын ажиглалтын үйлчилгээ

- Нислэгийн зам дагуух цаг агаарын нөхцөлийг ажиглах

## 3. ИНД174.103. (4) БОЛОВСРУУЛАН ГАРГАХ ЦАГ УУРЫН МЭДЭЭЛЭЛ, ХАНГАЖ БАЙГАА ЦАГ УУРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН БОЛОН ЧАНАРЫН МИНИМУМ ТҮВШИН

### 3.1 Боловсруулан гаргах цаг уурын мэдээний чанарын минимум түвшин

Боловсруулан гаргах цаг уурын мэдээлэл, хангаж байгаа цаг уурын үйлчилгээний гүйцэтгэл нь "Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах журам" 1 дүгээр дэвтэрт тусгагдсан ба TAF мэдээнд орох тоон элементүүдийн хязгаарын утга ба нарийвчлал нь бүлэг 6

нэмэлт 4, урьдчилсан мэдээний чанарын минимум түвшин нэмэлт 10-т, SIGMET/AIRMET мэдээ, аэродромын болон шилжлэг салхины сэрэмжлүүлэг мэдээнд орох тоон элементүүдийн хязгаарын утга ба нарийвчлал бүлэг 7 нэмэлт 5-д нийцсэн байна.

Хүснэгт 6. TAF мэдээнд орох тоон элементүүдийн хязгаарын утга ба нарийвчлал

| Элемент | | Хязгаарын утга | Нарийвчлал |
|---|---|---|---|
| Салхины чиглэл: | $^0$градус | 000 – 360 | 10 |
| Салхины хурд: | MPS | 00 – 99 | 1 |
| Алсын барааны харагдац: | M<br>M<br>M<br>M | 0000 – 0800<br>0800 – 5000<br>5000 – 9000<br>9000 – 9999 | 50<br>100<br>1000<br>999 |
| Босоо алсын барааны харагдац: | 30 М (100 фут) | 000 – 020 | 1 |
| Үүл: үүлний суурийн өндөр: | 30 М (100 фут) | 000 – 100 | 1 |
| Агаарын болон шүүдэр унах цэгийн температур: | °C | -80 – +60 | 1 |

Хүснэгт 7. Урьдчилсан мэдээний чанарын минимум түвшин

| Урьдчилан мэдээлж буй элемент | Урьдчилсан мэдээний онч (хүлцэж болох хязгаарлал) | Хангамж |
|---|---|---|
| **А. Нисэх буудал орчмын урьдчилсан мэдээ** | | |
| Салхины чиглэл | $\pm 20^0$ | Тохиолдлын 80% |
| Салхины хурд | ± 2м/с | Тохиолдлын 80% |
| Алсын барааны харагдац | 800м хүртэл ± 200м<br>800м-ээс 10км хүртэл ±30% | Тохиолдлын 80% |
| Үүлний хэмжээ | 1500м хүртэл өндөртэй BKN эсвэл OVC хэмжээтэй үүл ажиглагдсан буюу ажиглагдаагүй | Тохиолдлын 70% |
| Үүлний доод суурийн өндөр | 300м хүртэл ± 30м<br>300м-ээс 3000м хүртэл ±30% | Тохиолдлын 70% |
| Цаг агаарын үзэгдэл (Кодын хүснэгт 4678) | Ажиглагдсан буюу ажиглагдаагүй | |
| Агаарын температур | $\pm 1^0$C | Тохиолдлын 70% |
| **Б. Суулт, Хөөрөлтийн урьдчилсан мэдээ** | | |
| Салхины чиглэл | ±20° | Тохиолдлын 90% |
| Салхины хурд | ± 2м/с | Тохиолдлын 90% |
| Алсын барааны харагдац | 800м хүртэл ± 200м<br>800м-ээс 10 км хүртэл ±30% | Тохиолдлын 90% |
| Үүлний хэмжээ | 1500м хүртэл өндөртэй BKN эсвэл OVC хэмжээтэй үүл ажиглагдсан буюу ажиглагдаагүй | Тохиолдлын 90% |
| Үүлний доод суурийн өндөр | 300м хүртэл ± 30м<br>300м-ээс 3000м хүртэл ±30% | Тохиолдлын 90% |
| Цаг агаарын үзэгдэл (Кодын хүснэгт 4678) | Ажиглагдсан буюу ажиглагдаагүй | |
| Агаарын температур | $\pm 1^0$C | Тохиолдлын 90% |

| | | |
|---|---|---|
| Даралт (QNH) | ±1гПа | Тохиолдлын 90% |
| **В. Нислэгийн замын болон районы урьдчилсан мэдээ** | | |
| Өндрийн салхины чиглэл | ± 30° (900км-ийн зайн дундаж утга нь) байх эсэх | |
| Өндрийн салхины хурд | ± 20 км/цаг (900км-ийн зайн дундаж утга нь) | |
| Үүлшил болон нислэгийн чиглэл дэх цаг агаарын үзэгдэл | Ажиглагдсан буюу ажиглагдаагүй<br>байршил ± 100км<br>босоо чиглэл дэх зай ± 300м | |
| Давхаргын температур | ±2$^0$С (900км-ийн зайн дундаж утга нь) | |
| Тропопаузын өндөр | ±300м | |
| Хамгийн их салхины түвшин | ±300м | |

### 3.2 Цаг уурын мэдээний өгөгдөл цуглуулах

Цаг уурын мэдээний өгөгдлийг цуглуулахад тавигдах шаардлагыг “Нислэгийн цаг уурын үйлчилгээний байгууллагын ерөнхий заавар”-т тусгагдсан болно.

3.2.1 Дараах цаг уурын мэдээ, мэдээллийн өгөгдлийг цуглуулна. Үүнд:

a) Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага (НЦУҮБ) болон нисэх буудлуудаас гэрчилгээжсэн цаг уурын бодит ажиглалтын систем, эсхүл станц ашиглаж гаргасан нисэхийн цаг уурын болон уур амьсгалын бодит ажиглалтын мэдээ
b) Дэлхийн болон бүсийн урьдчилан мэдээлэх төв (WAFS)-үүдээс гаргаж буй бүх төрлийн бүтээгдэхүүнүүд
c) Хиймэл дагуулын мэдээлэл (HIMAWARICAST)
d) НЦУТ, ЦУОШГ, УЦУОСМХ-ээс гаргаж буй бүх төрлийн мэдээ, мэдээлэл
e) Морин-Уул локатор, цаг уурын станцын үүл, хур тунадас, салхины мэдээлэл
f) Орон нутгийн нисэх буудлуудын цаг агаарын бодит ажиглалтын болон урьдчилсан мэдээ
g) Интернэтэд суурилсан төрөл бүрийн тоон загварын үр дүн болон бүтээгдэхүүнүүд
h) Нислэгийн төлөвлөгөө

3.2.2 Цаг агаарын мэдээ, мэдээллийн өгөгдлийг дараах хаяг, суваг болон төхөөрөмжүүдийг ашиглан тогтоосон хуваарийн дагуу цуглуулна. Үүнд:

a) НЦУҮБ-уудаас **mnub@namhem.go.mn**, **ftp://192.168.110.30/**, http://www.amc.namem.gov.mn хаягаар
b) Телефон утаснууд:
УЦУОШТ-ийн 70374161
c) Цахим хуудас: http://www.amc.namem.gov.mn
d) Цахим шуудан: info@darkhan-uul.namem.gov.mn

### 3.3 Мэдээ, мэдээллийг түгээх, дамжуулах

3.3.1 УЦУОШТ-өөс дараах мэдээ, мэдээллүүдийг тогтоосон хуваарийн дагуу боловсруулан гаргана. Үүнд:

a) Богино хугацааны тойм урьдчилсан мэдээ
b) Районы урьдчилсан мэдээ
c) Чиглэлийн болон Угталтын урьдчилсан мэдээ

3.3.2 Цаг агаарын мэдээ, мэдээллийг дараах сувгуудаар дамжуулна. Үүнд:

a) Интернэтэд суурилсан “Нислэгийн цаг уурын мэдээ дамжуулах систем”-МДС
b) Телефон утаснууд:

Нислэгийн цаг уурын төв: 71287279, 71287419, 91287279, 71283039
d) Цахим шуудан: info@darkhan-uul.namem.gov.mn

**3.4 Мэдээг бичих бүдүүвч болон дамжуулах цагийн хуваарийг чанд баримтална**

a) Буудал орчмын богино хугацааны урьдчилсан мэдээ (FC)-г 1 цагаас өмнө дараах хуваарийн дагуу зохион дамжуулна.

Хүснэгт 8. Мэдээ дамжуулах хуваарь

| Хугацаа (ОУДЦ) | 9 цагийн TAF | |
|---|---|---|
| | Үйлчлэх хугацаа | Мэдээ дамжуулах хугацаа (ОУДЦ) |
| 00 | dd00/dd09 | 23.00 |
| 03 | dd03/dd12 | 02.00 |
| 06 | dd06/dd15 | 05.00 |
| 09 | dd09/dd18 | 08.00 |
| 12 | dd12/dd21 | 11.00 |
| 15 | dd15/dd24 | 14.00 |
| 18 | dd18/DD03 | 17.00 |
| 21 | dd21/DD06 | 20.00 |

*Тайлбар: dd - өмнөх өдөр, DD - дараах өдөр*

b) Богино хугацааны урьдчилсан мэдээг орон нутгийн нислэг эхэлснээс дуусах хүртэл хугацаанд зохиож дамжуулна.

c) BBB – бүлэг нь мэдээнд нарийвчлал хийх, засвар оруулах, хугацаа хоцорсон эсэхийг илэрхийлнэ. Үүнд:

**AAX** – Урьдчилсан мэдээ нарийвчилсан (**AMD**):
- **AAA** – Эхний нарийвчлал
- **AAB** – Хоёр дахь нарийвчлал

**CCX** – Цаг агаарын мэдээ засварласан (**COR**):
- **CCA** – Эхний засвар
- **CCB**– Хоёр дахь засвар

**RRX** – Цаг агаарын урьдчилсан мэдээ хоцорсон:
- **RRA**– 06 – 20минут хоцроосон бол
- **RRB**– 21 – 40 минут хоцроосон бол
- **RRC** – 41 минутаас дээш хоцроосон бол

## 4. ИНД174.103. (5) СҮЛЖЭЭ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

**4.1 Сүлжээ, тоног төхөөрөмж**

4.1.1 Цаг уурын дотоод сүлжээгээр НЦУҮБ-уудтай цаг агаарын мэдээ, мэдээллийг цаг тухайд нь хүлээн авч, солилцоно.

4.1.2 Нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа сүлжээ, тоног төхөөрөмж, технологийн компьютерийн хэвийн ажиллагаа, нисэхийн цаг агаарын мэдээлэл дамжуулах, хүлээн авах программ хангамжийн тасралтгүй, найдвартай ажиллагааг сүлжээ, тоног төхөөрөмжийг хариуцан ажиллах албан хаагч ажиллана. Гэмтэл гарсан тохиолдолд холбогдох арга хэмжээг шуурхай авч ажиллах үүрэгтэй. Түүний найдвартай ажиллагааг бататгахын тулд тоног төхөөрөмжид үзлэг шалгалт, техник үйлчилгээг батлагдсан хуваарийн дагуу хийгдсэн эсэхэд ЦУМҮХ-ийн дарга хяналт тавина.

4.1.3 Цаг уурын сүлжээнд гэмтэл саатал гарсан тохиолдолд УЦУОСМХ-ийн Цаг уурын холбоо, мэдээллийн хэлтэст хандаж гэмтлийг арилгуулах арга хэмжээг авч ажиллана. Ажиллагааг хэвийн болтол утсан холбоо, интернэт сүлжээгээр мэдээллийг солилцож, үйл ажиллагааг хэвийн тасралтгүй байлгах арга хэмжээг авч ажиллана.

4.1.4 Тоног төхөөрөмжийг хариуцан ажиллах албан хаагч нь цаг агаарын мэдээ боловсруулах үйлчилгээнд ашиглах сүлжээ, тоног төхөөрөмжид үүссэн гэмтэл саатлын шалтгааныг нарийвчлан тогтоох, бүртгэх, арилгах арга хэмжээг шуурхай авах бөгөөд засагдах боломжгүй гэмтэл саатлыг УЦУОШТ-ийн даргад мэдэгдэж шийдвэрлүүлнэ.

### 4.2 Бататгах, хугацаат үзлэг шалгалт, тест тохируулга хийх

4.2.1 ОУИНБ-ын баримт бичиг №9837 "Аэродром дэх цаг уурын автомат ажиглалтын системийн гарын авлага", ДЦУБ-ын цуврал №08 "Ажиглалт хийх арга зүй ба тоног төхөөрөмжийн заавар"-т тусгагдсан шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжийг нисэхийн цаг уурын үйлчилгээнд ашиглана.

4.2.2 Нисэхийн үйлчилгээнд ашиглаж буй хэрэглээний компьютер, тог баригч, хувилагч төхөөрөмжийн хугацаат үзлэг шалгалтын календарьчилсан төлөвлөгөөг УЦУОШТ-ийн даргаар батлуулж, хуваарийн дагуу тоног төхөөрөмж хариуцсан ажилтан хийж гүйцэтгэнэ.

### 4.3 Осол, эсхүл зөрчлийн дараа цаг уурын мэдээллийг шалгах

Энэхүү үйл явцыг НЦУТ-ийн даргын 2021 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан "Осол, эсхүл зөрчлийн дараа цаг уурын мэдээллийг шалгах журам"-аар зохицуулна.

### 4.4 Алдаатай мэдээлэл

Тоног төхөөрөмжийн доголдлыг НЦУТ-ийн ээлжийн синоптик инженер 71287279, 71287419, 91287279, 71283039, Аюулгүй ажиллагаа, чанарын менежерийн 71283053 дугаарын утсаар мэдэгдэнэ. Алдаатай мэдээллийг таньж тогтоох, бүртгэх, мэдэгдэх, шинжлэн шалгах болон залруулах үйл ажиллагааг НЦУТ-ийн даргын 2021 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан "Үл тохирох бүтээгдэхүүний хяналтын журам", "Залруулах арга хэмжээний журам", "Эрсдэлийн үнэлгээ хийх журам", "Нислэгийн цаг агаарын таараагүй мэдээнд дүн шинжилгээ хийх журам"-аар тус тус зохицуулна.

### 4.5 Бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, арчлах болон устгах

4.5.1 Цаг уурын үйлчилгээг явуулахад шаардагдах заавар, журам, тоног төхөөрөмжийн гарын авлага, техник ашиглалтын зааварчилга болон бусад баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа мөрдөн, хяналт тавин ажиллана.

4.5.2 УЦУОШТ-өөс гаргаж, дамжуулж буй мэдээ мэдээллийг мэдээллийн сан үүсгэж, цаасан болон цахим хэлбэрээр "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ыг жил бүр шинэчлэн УЦУОШТ-ийн даргаар батлуулан хадгаламжийн нэгж үүсгэн архивт хадгална (2021 оны "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам").

## 5. ИНД174.103. (6) ЦАГ УУРЫН МЭДЭЭЛЛИЙГ ГАРГАХАД ЗААВАЛ МӨРДӨХ ШААРДЛАГАТАЙ ШАЛГАЛТЫН ЖУРАМ

### 5.1 Цаг агаарын бодит болон урьдчилсан мэдээг гаргах

НЦУТ-ийн даргын 2021 онд баталсан интернэт сүлжээний орчинд нислэгт зориулсан цаг уурын мэдээ, мэдээллийг боловсруулан гаргах, өгөгдөл цуглуулах, мэдээлэлд хяналт тавихад "Нислэгийн цаг уурын мэдээ дамжуулах ашиглалтын заавар"-ыг баримтлан "Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах журам" 1, 2 дугаар дэвтрийн бүлэг 4 нэмэлт 2, бүлэг 6 нэмэлт 4, бүлэг 7 нэмэлт 5-д заасны дагуу цаг агаарын бодит болон урьдчилсан мэдээг боловсруулан гаргана.

# 6. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗААВРЫГ ХЯНАХ, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БОЛОН ТҮГЭЭХ

## 6.1 Хяналт тавих

6.1.1 Энэ зааврын өдөр тутмын үйл ажиллагаа холбогдох журам, зааврууд, аюулгүй ажиллагааны шаардлагуудад нийцэж байгаа эсэхэд УЦУОШТ-ийн ЦУМҮХ-ийн дарга байнгын хяналт тавьж ажиллана.

6.1.2 НЦУТ-ийн ААЧХХ нь баримт бичгийн хяналт, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хийгддэг үзлэг шалгалт, төлөвлөгөөт үзлэг шалгалт хийнэ.

## 6.2 Нэмэлт, өөрчлөлт оруулах

6.2.1 Дараах тохиолдлуудад нэмэлт, өөрчлөлтийг оруулна. Үүнд:

a) Холбогдох ИНД-үүдэд өөрчлөлт орсон.
b) ЦУОШГ болон ИНЕГ-аас гаргасан УЦУОШТ-ийн үйл ажиллагаатай холбогдолтой заавар, журмуудад өөрчлөлт орсон.
c) Ерөнхий заавар болон заавал мөрдөх шаардлагатай заавар, журмуудын хооронд үл нийцэл үүссэн.
d) Аюулгүй байдал, үйлдвэрлэлийн үр өгөөжийг дээшлүүлэх, үйл ажиллагааг хялбаршуулах үүднээс УЦУОШТ-ийн өдөр тутмын үйл ажиллагааны зохицуулалтад өөрчлөлт оруулах шаардлага гарсан.
e) УЦУОШТ-ийн зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлт орсон.
f) УЦУОШТ-ийн удирдлага, салбар хариуцсан албан тушаалтанд өөрчлөлт орсон.
g) Эрхэлж буй ажил, үйлчилгээний жагсаалтад өөрчлөлт орсон тохиолдолд.
h) Байгууллагын байрлал болон үйлчлэх нутаг дэвсгэрийн хэмжээ өөрчлөгдөх

6.2.2 Албан хаагч нь Үйл ажиллагааны зааварт өөрчлөлт оруулах санал гаргах эрхтэй. Санал гаргагч нь зааварт нэмэлт өөрчлөлт оруулах саналаа дэлгэрэнгүй тайлбарын хамт УЦУОШТ-ийн даргын зөвлөлд бичгээр гаргаж өгнө.

6.2.3 УЦУОШТ-ийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэсэн холбогдох өөрчлөлтүүдийг НЦУТ-д ирүүлж хянуулна.

6.2.4 Зааварт нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж мөрдөж эхлэхээс 7 хоногийн өмнө УЦУОШТ-ийн салбар, нэгжүүдэд мэдэгдэнэ.

6.2.5 Нэмэлт, өөрчлөлтийг дараах мэдээллийн дагуу оруулна. Үүнд:

a) Өөрчлөлтийн дугаар
b) Өөрчлөлт оруулсан огноо
c) Өөрчлөлтийн тайлбар
d) Өөрчлөлт оруулсан албан тушаалтны нэр

8.2.6 "Үйл ажиллагааны заавар"-ын өөрчлөлт орсон хуудас бүрт мөн хүчинтэй хуудасны жагсаалтад өөрчлөлтийн хүчин төгөлдөр болсон огноог тэмдэглэнэ.

## 6.3 Түгээх

6.3.1 Үйл ажиллагааны зааварт хийгдсэн нэмэлт, өөрчлөлтийг бүртгэлд оруулах ажлыг УЦУОШТ-ийн ЦУМҮХ-ийн дарга гүйцэтгэнэ.

6.3.2 Батлагдан гарсан нэмэлт, өөрчлөлтийг "Үйл ажиллагааны заавар"-ын хяналттай хувиуд байгаа хэлтэс, нэгжүүд болон холбогдох албан тушаалтанд бичгээр болон цахимаар түгээнэ.

# Хавсралт 1

Төрийн албаны зөвлөлийн
2019 оны 03 дугаар тогтоолын
хоёрдугаар хавсралт

# УРЬДЧИЛСАН МЭДЭЭЛЭХИЙН ЕРӨНХИЙ ТЕХНОЛОГИЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

| I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ | |
|---|---|
| **Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:** Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан<br><br>**Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:** Төрийн албаны тухай хууль, 2017 оны 12 дугаар сарын 07 -ны өдөр<br><br>**Дагаж мөрдөх огноо:** 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс | |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | 2020 оны 03 сарын 25 өдөр |
| Байгууллагын нэр: Дархан-Уул аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний Төв | Нэгжийн нэр: Цаг уур, мэдээлэл үйлчилгээний хэлтэс |
| Албан тушаалын нэр: Урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич | Албан тушаалын ангилал, зэрэглэл: Төрийн үйлчилгээ, ТҮ-8 |
| Ажлын цаг: Ажлын өдөр, 8 цаг | Ажлын байрны албан ёсны байршил: Дархан сум, 5 дугаар баг, УЦУОШТ |
| Хөдөлмөрийн нөхцөл: Хэвийн | Онцгой нөхцөл: Хамаарахгүй |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

**Албан тушаалын зорилго:** Цаг агаарын бүх төрлийн урьдчилсан мэдээ, тусгай хэрэгцээний мэдээг өндөр тааруцтай зохиож хэрэглэгчдэд шуурхай үйлчлэх, нислэгийн цаг агаарын мэдээгээр үйлчлэх

**Албан тушаалын зорилт:**

1. Үндсэн чиг үүрэг, бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх;
2. Ус, цаг уур, орчны мэдээллээр үйлчлэх;
3. Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах;

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1. Мэдээлэл үйлчилгээний ажлын нэгдсэн хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах;<br>2. Нислэгийн цаг агаарын үйл ажиллагааны зааврыг мөрдөж ажиллах; | Төрийн албаны хэвгчийн ажлын хариуцлага, ажил гүйцэтгэх чадвар | Хариуцан гүйцэтгэх |

| | | | |
|---|---|---|---|
| | тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;<br>4. Байгаль цаг агаарын аюултай үзэгдэл, давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл бүрдсэн үед тусгай горимд шилжих ажлыг зохион байгуулах;<br>5. Манлайлал, мэдлэг боловсорлоо дээшлүүлэх, шинээр нэвтэрч байгаа технологид суралцах; | | |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1. Цаг агаарын урьдчилсан мэдээ, мэдээллээр үйлчлэх ажлыг зохион байгуулах;<br>2. Нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчлэх ажилд хяналт тавих<br>3. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах; | Үнэн бодит мэдээллээр шуурхай үйлчилсэн байна. | Хянах, Хариуцан гүйцэтгэх |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1. Төрийн үйлчилгээний албан хаагчийн үйл ажиллагаанд хамааралтай хуулийг хэрэгжүүлэх;<br>2. Дээд газраас гаргасан тогтоол, захирамж, тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах;<br>3. Засгийн газар, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллах;<br>4. Шинээр батлагдаж мөрдөх хууль, тогтоолыг танилцуулах, ажилтаны мэргэшил, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах; | Хууль, тогтоол, шийдвэр бүрэн хэрэгжсэн байна. | Хариуцан гүйцэттэх |

| III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА | |
|---|---|
| **Боловсрол** | Магистр, түүнээс дээш |
| **Мэргэжил** | Цаг уур, Ус судлал, Мэдээллийн технологи, хүрээлэн буй орчин судлал |
| **Мэргэшил** | Мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтанд хамрагдсан байх |
| **Туршлага** | Мэргэжлээр 8-аас доошгүй, үүнээс ерөнхий технологичоор 5-аас доошгүй жил ажилласан байх |
| **Ур чадвар** | |
| Удирдан зохион байгуулах | Нэгжийн үйл ажиллагааг төлөвлөх, ажил үүргийг тэнцвэртэй оновчтой зөв хуваарилах, зохион байгуулах, гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах |
| | Багийн ажлын амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах, нээлттэй харилцааг бий болгох, мэдээллийг шуурхай хүргэх, солилцох боломжийг бүрдүүлэх |
| | Үйл ажиллагаан дахь эрсдлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах |
| | Ажилтаны шинэлэг санаа, шинэ санаачлага, бүтээлч хандлагыг дэмжих |
| Дүн шинжилгээ хийх | Албан хэрэгцээнд шаардлагатай мэдээллийг цуглуулах, дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах |
| | Шийдвэрийн эерэг болон сөрөг үр дагаварт дүн шинжилгээ хийж шийдлийн хувилбарын талаар зөвлөх |

| | |
|---|---|
| Асуудал шийдвэрлэх | Тулгамдсан асуудлыг оновчтой, үр дүнтэй зөв шийдэх хувилбарыг боловсруулах, санал дэвшүүлэх |
| | Аливаа шийдвэрийг гаргахдаа хамт олны саналыг тусгах |
| Манлайлах | Ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанараараа бусдыг үлгэрлэн манлайлах |
| | Байгууллагын нэгжийн үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх |
| | Албан үүргээ хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид гүйцэтгэх |
| | Хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалт сайтай байх |
| Бусад | Албан бичиг боловсруулах, албан хэрэг хөтлөх |
| | Гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгтээ хамаарах мэдээллийн эх сурвалжийг цуглуулах нэгтгэх |
| | Судалгааны ажил хийх |

## IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Ус цаг уур орчны шинжилгээний Төвийн дарга

| Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо: | Бусад харилцах субъект: |
|---|---|
| 1. Ерөнхий технологич, инженер - 8<br>2. Өртөөний техникч -8<br>3. Агро цаг уурын техникч-2<br>4. Харуулын ажиглагч -2<br><br>Нийт: 20 | 1. ЦУОШГ-ын хэлтсийн мэргэжилтэн<br>2. НЦУТ-ийн мэргэжилтэн<br>3. УЦУОСМХ-ийн холбогдох хэлтсийн мэргэжилтэн<br>4. Төрийн бус байгууллагын байгууллагын холбогдох мэргэжилтэн<br>5. ААНБ, иргэн |

## V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| **Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:** | **Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах, зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:** |
|---|---|
| Албан тушаал: УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГА<br>[signature] ............ Ciimangaeuon<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br><br>2020 оны 03 дугаар сарын 20 -ны өдөр | Байгууллагын нэр: ..........<br>Шийдвэрийн огноо: ..........<br>Дугаар: .......... |

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

Байгууллагын нэр: ДАРХАН-УУЛ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Шийдвэрийн огноо: 2020.03.25

Дугаар: 01/4

(тамга/тэмдэг)

[signature] ..........

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2020 оны 03 дугаар сарын 25 -ны өдөр

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

Байгууллагын нэр: ДАРХАН-УУЛ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
Шийдвэрийн огноо: 2020.03.25
Дугаар: А/04

(тамга/тэмдэг)

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2020 оны 03 дугаар сарын 25 ны өдөр

**Албан тушаалын тодорхойлолттой танилцсан:**

Байгууллагын нэр: ДАРХАН-УУЛ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
Танилцсан огноо 2021.03.09
Гарын үсэг

Журамбаатар Мөнгөнцэцэг
/эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр

Төрийн албаны зөвлөлийн
2019 оны 03 дугаар тогтоолын
хоёрдугаар хавсралт

# УРЬДЧИЛСАН МЭДЭЭЛЭХИЙН ЕРӨНХИЙ ТЕХНОЛОГИЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

**Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:** Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

**Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:** Төрийн албаны тухай хууль, 2017 оны 12 дугаар сарын 07 -ны өдөр

**Дагаж мөрдөх огноо:** 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс

| | |
|---|---|
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | 2020 оны 03 сарын 25 өдөр |
| Байгууллагын нэр: Дархан-Уул аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний Төв | Нэгжийн нэр: Цаг уур, мэдээлэл үйлчилгээний хэлтэс |
| Албан тушаалын нэр: Урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич | Албан тушаалын ангилал, зэрэглэл: Төрийн үйлчилгээ, ТҮ-8 |
| Ажлын цаг: Ажлын өдөр, 8 цаг | Ажлын байрны албан ёсны байршил: Дархан сум, 5 дугаар баг, УЦУОШТ |
| Хөдөлмөрийн нөхцөл: Хэвийн | Онцгой нөхцөл: Хамааралгүй |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

**Албан тушаалын зорилго:** Цаг агаарын бүх төрлийн урьдчилсан мэдээ, тусгай хэрэгцээний мэдээг өндөр таарцтай зохиож хэрэглэгчдэд шуурхай үйлчлэх, нислэгийн цаг агаарын мэдээгээр үйлчлэх

**Албан тушаалын зорилт:**

1. Үндсэн чиг үүрэг, бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх;
2. Ус, цаг уур, орчны мэдээллээр үйлчлэх;
3. Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах;

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1. Мэдээлэл үйлчилгээний ажлын нэгдсэн хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах;<br>2. Нислэгийн цаг агаарын үйл ажиллагааны зааврыг мөрдөж ажиллах; | Төрийн албаны хаагчийн ажлын хариуцлага, ажил гүйцэтгэх чадвар | Хариуцан гүйцэтгэх |

| | | | |
|---|---|---|---|
| | 3. ХАБЭА-н тухай хууль, ХАА-ны журам, зааварчилгааг мөрдөх;<br>4. Төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх;<br>5. Байгаль цаг агаарын аюултай үзэгдэл, давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл бүрдсэн үед тусгай горимд шилжин ажиллах;<br>6. Манлайлал, мэдлэг боловсролоо дээшлүүлэх, шинээр нэвтэрч байгаа технологид суралцах; | сайжирсан байна. | |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1. Цаг агаарын урьдчилсан мэдээ, АҮ, ГҮ-ийн мэдээ, тусгай хэрэгцээний мэдээгээр шуурхай үйлчлэх;<br>2. Нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчлэх<br>3. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах; | Үнэн бодит мэдээллээр шуурхай үйлчилсэн байна. | Хариуцан гүйцэтгэх |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1. Төрийн үйлчилгээний албан хаагчийн үйл ажиллагаанд хамааралтай хуулийг хэрэгжүүлэх;<br>2. Дээд газраас гаргасан тогтоол, захирамж, тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах;<br>3. Засгийн газар, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллах;<br>4. Шинээр батлагдаж мөрдөх хууль, тогтоолтой танилцаж, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, хэрэгжүүлэх; | Үнэн бодит мэдээллээр шуурхай үйлчилсэн байна. | Хариуцан гүйцэтгэх |

| III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА | |
|---|---|
| Боловсрол | Бакалавр түүнээс дээш |
| Мэргэжил | Цаг уурч |
| Мэргэшил | Урьдчилсан мэдээлэхийн чиглэлээр мэргэшүүлэх сургалтанд хамрагдаж ажиллах эрх, нисэхийн цаг уурт үйлчлэх эрх тус тус авсан байх |
| Туршлага | Инженерээр 3-оос доошгүй жил ажилласан байх |
| Ур чадвар | |
| Удирдан зохион байгуулах | Нэгжийн үйл ажиллагааг төлөвлөх, ажил үүргийг тэнцвэртэй оновчтой зөв хуваарилах, зохион байгуулах, гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах |
| | Багийн ажлын амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах, нээлттэй харилцааг бий болгох, мэдээллийг шуурхай хүргэх, солилцох боломжийг бүрдүүлэх |
| | Үйл ажиллагаан дахь эрсдлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах |
| | Ажилтаны шинэлэг санаа, шинэ санаачлага, бүтээлч хандлагыг дэмжих |
| Дүн шинжилгээ хийх | Албан хэрэгцээнд шаардлагатай мэдээллийг цуглуулах, дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах |
| | Шийдвэрийн зөрөг болон сөрөг үр дагаварт дүн шинжилгээ хийж шийдлийн хувилбарын талаар зөвлөх |
| Асуудал | Тулгамдсан асуудлыг оновчтой, үр дүнтэй зөв шийдэх хувилбарыг |

| | |
|---|---|
| шийдвэрлэх | боловсруулах, санал дэвшүүлэх |
| | Аливаа шийдвэрийг гаргахдаа хамт олны саналыг тусгах |
| Манлайлах | Ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанараараа бусдыг үлгэрлэх |
| | Байгууллагын нэгжийн үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх |
| | Албан үүргээ хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид гүйцэтгэх |
| | Хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалт сайтай байх |
| Бусад | Албан бичиг боловсруулах, албан хэрэг хөтлөх |
| | Гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгтэй хамаарах мэдээллийн эх сурвалжийг цуглуулах нэгтгэх |
| | Судалгааны ажлын арга зүй, илтгэх чадвар эзэмшсэн байх |

## IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

1. Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга
2. Цаг уур, мэдээлэл үйлчилгээнийй хэлтсийн дарга

| Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо: | Бусад харилцах субъект: |
|---|---|
| Өртөөний инженер - 2<br>Өртөөний техникч - 8<br>Харуулын ажиглагч - 2<br><br>Нийт 12 | 1. ЦУОШГ-ын хэлтсийн мэргэжилтэн<br>2. НЦУТ-ийн мэргэжилтэн<br>3. Иргэд, орон нутгийн аж ахуйн нэгж, төрийн байгууллага<br>4. Хэвлэл, мэдээллийн байгууллагууд<br>5. 101, 102, 103 байгууллага<br>6. Цаг агаарын мэдээгээр үйлчлэх гэрээт байгууллагууд<br>7. Онцгой тохиолдолд бусад субъект |

## V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| **Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:** | **Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах, зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:** |
|---|---|
| Албан тушаал: ЦАГ УУР, МЭДЭЭЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА<br><br>Б. Этэмбаатар ........ (Гарын үсэг)<br>Б. Этэмбаатар ........ (Эцэг/эх/ийн нэр, өөрийн нэр)<br><br>2020 оны 03 дугаар сарын 20-ны өдөр | Байгууллагын нэр: ..........<br>Шийдвэрийн огноо: ..........<br>Дугаар: .......... |

# Хавсралт 2

**ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**

**НИ-2**

Буудлын нэр ____________________

20 .... оны .... сарын .... өдрийн .... цаг .... минутаас .... цаг .... минут хүртэл

Зохиосон .......... цаг ........ минут

Хүлээлгэн өгсөн .......... цаг ........ минут

Синоптик ..............................................

Диспетчер ..............................................

## *Агаарын хөлгийн цаг агаарын ажиглалтын мэдээ*

| № | Огноо | Мэдээний утга | Мэдээ өгсөн | Хүлээн авсан | Цаг минут |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

### *Хяналт, шалгалт хийх хуудас*

| **№** | **Огноо** | Урьдчилсан мэдээ | Гаргасан алдаа | Шалгасан инженер | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

## Осол зөрчлийг мэдээлэх хуудас

Хүлээн авсан: …………. оны …... сарын……..цаг……минут

| Мэдээллийн товч утга | | | | |
|---|---|---|---|---|
| № | Нислэгийн аялалын дугаар | Хаана | Хэзээ | Осол, зөрчлийн төрөл |
| | | | | |

Мэдээлэл гаргасан:…………………………./     гарын үсэг     /

………………………………………………………………………/овог, нэр /
………………………………………………………………………/Албан тушаал/
………………………………………………………………………/ Он сар өдөр/

Мэдээлэл хүлээн авсан: …………………………./     гарын үсэг     /

………………………………………………………………………/овог, нэр /
………………………………………………………………………/Албан тушаал/
………………………………………………………………………/ Он сар өдөр/

Мэдээлэл дамжуулсан: …………………………./     гарын үсэг     /
………………………………………………………………………/овог, нэр /
………………………………………………………………………/Албан тушаал/
………………………………………………………………………/ Он сар өдөр/




**2015 оны сарын өдөр** TAF

АЯЛАЛЫН ДУГААР: ДУГААР:

ОНГОЦНЫ МАЯГ:

НИСЛЭГИЙН ЧИГЛЭЛ:

НИСЭХ ХУГАЦАА:

АЭРОСИНОПТИК НӨХЦӨЛ:

| | | Алаг хад кэмп | | | |
|---|---|---|---|---|---|
| Өндрийн салхи (км/цаг) температур (°C) | 4000<br>3000<br>2000 | | | | |
| Үүлшилт | | | | | |
| Газрын гадаргуугийн алсын барааны харагдац (м) | | | | | |
| Цаг агаарын аюултай үзэгдэл | | | | | |
| Нэмэлт мэдээлэл | | | | гПа | |

METAR

Синоптик инженер ..............................................

Нисэх багийн дарга ..............................................


2020 оны 1 сарын 8 өдөр
Дугаар
Нислэгийн чиглэл
Нислэгийн хугацаа
Аэросиноптик нөхцөл
TAF
Copy
METAR
Өндрийн салхи (км/ц), Температур (цельс)
0°C-ийн изотермийн өндөр (м)
Тропопаузын өндөр (м)
гПа
Синоптик инженер
Нисэх багийн дарга

……………………….. аймгийн УЦУОШТ

# ЭЭЛЖ ХҮЛЭЭЛЦЭХ ДЭВТЭР

ЭХЭЛСЭН ОГНОО:…………………

ДУУССАН ОГНОО:…………………

20…. оны ……. сарын …… өдөр …… цаг ……. минутаас …… цаг ….. минут

## Зураг мэдээний ирцийн хяналтын хуудас

| № | Прогноз зураг мэдээ | 00 | 06 | 12 | 18 | № | Бодит цаг агаарын зураг | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Европын дунд хугацааны тоон прогнозын үр дүн ECMWF | | X | | X | 1 | Орчны цаг агаарын зураг | 02 05 08 11 14 17 20 23 |
| 2 | NCEP-Global Forecast System | | | | | 2 | Газрын цаг агаарын зураг | 08 12 |
| 3 | Японы тоон прогнозын үр дүн | | | | | 3 | Өндрийн цаг агаарын зураг | 08 12 |
| 4 | ММ5 загварын үр дүн | | X | | X | 4 | Радио зондын мэдээ | |
| 5 | WRF загварын үр дүн | | X | | X | 5 | FY-2 хиймэл дагуулын үүлний зураг | |
| 6 | Стандарт түвшний өндрийн салхи температурын зураг | | | | | 6 | Цаг агаарын үзэгдэл элементийн хүснэгтэн мэдээлэл | 02 05 08 11 14 17 20 23 |
| 7 | WAFS онцгой үзэгдлийн зураг | | | | | 7 | Цаг уурын автомат станцын 5 минут тутмын мэдээ | |
| 8 | WAFS салхи, температурын зураг | | | | | 8 | HIMAWARI Cast хиймэл дагуулын үүлний зураг | |
| 9 | НЦУТ WRF тоон загвар | | | | | | | |

## Тоног төхөөрөмжийн хяналтын хуудас

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Автомат станц | | 3 | Принтер | |
| 2 | Компьютер | | 4 | UPS | |

## Сүлжээний бүртгэл

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Интернет | | 2 | Цаг уур | |

## Үйлчилсэн нислэгийн тоо

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн нислэг | | 2 | Бэлтгэл аэродром | |

## Үйлчилсэн мэдээний тоо

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | TAF TOIM | | | | |
| 2 | РАЙОН | | | | |
| 3 | НИ-5 | | | | |
| 4 | Угталт | | | | |
| 5 | 7 хоногийн төлөв | | | | |

## Дамжуулсан мэдээний тоо

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | METAR | | 3 | TAF | |
| 2 | SPECI | | 4 | | |

Тайлбар:

………………………………………………………………………………………………………………………………………………

………………………………………………………………………………………………………………………………………………

………………………………………………………………………………………………………………………………………………

………………………………………………………………………………………………………………………………………………

Ээлж хүлээлгэн өгсөн синоптик инженер…………………………………/
/

……. цаг…… минут

Ээлж хүлээн авсан синоптик инженер………………………………………/
/

……. цаг…… минут

## *Цаг агаараас шалтгаалсан нислэгийн саатлын бүртгэл*

| № | Огноо | Аялалын дугаар | Нислэгийн чиглэл | Агаарын хөлгийн маяг | Хөөрөх буух цаг | Хөөрсөн буусан цаг | Саатсан шалтгаан | Саатлын төрөл | Синоптик инженерийн нэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |

БАТЛАВ.
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
С.МӨНХНАСАН

БАТЛАВ.
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
С.ЭНХТҮВШИН

20 21 оны 12 сарын 06 өдөр    №25/4 1.2021/әу-29    Улаанбаатар хот

# НИСЛЭГТ ЦАГ АГААРЫН МЭДЭЭГЭЭР ҮЙЛЧЛЭХ, МЭДЭЭГ ХЭРЭГЛЭХ ТАЛААР ХАМТРАН АЖИЛЛАХ ЕРӨНХИЙ ГЭРЭЭ

Нислэгт цаг уурын мэдээгээр үйлчлэх, мэдээг хэрэглэх үйл ажиллагааг зохицуулах зорилгоор нэг талаас Иргэний нисэхийн ерөнхий газар (ИНЕГ) түүнийг төлөөлөн Агаарын навигаци, нисэх буудлын бодлого зохицуулалтын газрын дарга Д.Эрдэнэбаатар /цаашид "Мэдээ хэрэглэгч" гэх/, нөгөө талаас Цаг уур, орчны шинжилгээний газар (ЦУОШГ)-ыг төлөөлөн Дэд дарга Б.Баттулга /цаашид "Мэдээгээр үйлчлэгч", хамтад нь "хоёр тал" гэх/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

## НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1 Гэрээг байгуулахад Чикагогийн конвенцийн 3 дугаар хавсралт, Дэлхийн цаг уурын байгууллага, Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, шаардлага, зөвлөмж, Монгол Улсын Иргэний хууль, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулиудыг тус тус үндэслэл болгов.

1.2 Нислэгийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор агаарын хөлгийн нислэгийг цаг агаарын мэдээгээр үйлчлэх, уг мэдээг хэрэглэх үйл ажилагааг зохицуулах түүнд хяналт тавихад энэхүү гэрээг мөрдлөг болгоно;

1.3 Нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчлэх ажлын зохион байгуулалт, мэргэжлийн удирдлагын үүргийг Цаг уур, орчны шинжилгээний газар, нислэгийн цаг агаарын мэдээний ашиглалтын харилцааг зохицуулах үүргийг Иргэний нисэхийн ерөнхий газар тус тус гүйцэтгэнэ.

1.4 Хоёр газрын даргын тушаалаар байгуулсан нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчлэх, мэдээг хэрэглэх талаар хамтран ажиллах ажлын хэсэг нь энэхүү гэрээний биелэлт болон, нислэгийн аюулгүй ажиллагааг хангах чиглэлээр гаргасан заавар, журам болон бусад эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавих, тулгамдсан асуудлыг зохицуулан шийдвэрлэх эрх, үүрэгтэйгээр ажиллана.

1.5 Нислэгийн цаг агаарын мэдээний үйлчилгээ, ашиглалтын талаар төв, орон нутгийн байгууллагуудаас ирсэн санал, хүсэлт, мэдээллийг хоёр талын хамтарсан ажлын хэсэг шуурхай хэлэлцэн шийдвэрлэх, ажлын хэсгийн хэмжээнд шийдвэрлэх боломжгүй асуудлыг хоёр газрын даргын зөвлөлийн хуралд тавьж шийдвэрлүүлнэ.

ИНЕГ
ХЯНАВ

1.6 Нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчлэх, мэдээг ашиглах чиглэлээр баримтлах журам, заавар зэрэг технологийн баримт бичгийг хоёр газрын даргын хамтарсан тушаалаар батлуулж мөрдүүлнэ.

1.7 Иргэний нисэхийн ерөнхий газар, Цаг уур, орчны шинжилгээний газар болон тэдгээрийн харьяа байгууллагуудын аль нэг нь техник, технологийн болон зохион байгуулалтын өөрчлөлт хийх, ажлын хүрээгээ өөрчлөх, заавар журам гаргах зэрэг асуудлыг шийдвэрлэхдээ төлөвлөлтийн үе шатанд нөгөө байгууллагадаа албан ёсоор мэдэгдэж үйл ажиллагаагаа зохицуулна.

1.8 Төв, орон нутгийн хэмжээнд сургалт, семинар, зөвлөгөөн, уулзалт, цугларалт зохион байгуулж, үйлдвэрлэлийн чанартай асуудал хэлэлцэх үедээ талууд харилцан төлөөлөгчөө урьж оролцуулж байна.

1.9 Нислэгийг цаг агаарын мэдээгээр үйлчлэх, ашиглах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, агаарын тээвэрлэгчид болон агаарын навигацийн үйлчилгээний байгууллага, нисэх буудлууд нь энэхүү ерөнхий гэрээг үндэслэн өөрсдийн ажил, үйлчилгээ, байршлын онцлогт тохируулан салбар гэрээ байгуулж ажиллана. Салбар гэрээнд дараах асуудлыг тусгана; Үүнд:

А) Нислэг үйлдэж буй бүх агаарын хөлгийн баг нислэгийн замд тохиолдсон цаг агаарын аюултай үзэгдлийг ажиглаж, үйлчлэгч байгууллагад хугацаа алдалгүй үнэн зөв мэдээлнэ;

Б) Нислэгийн цаг уурын тодорхой сэдвээр шинжилгээ, судалгаа хийх мэргэжлийн хүмүүст агаарын хөлгөөс ажиглалт, судалгаа явуулахад тусална;

В) Хамтран шалган зааварчилгаа хийх, нислэгийн саатал, зөрчлийн шалтгааныг тогтоох комиссын бүрэлдэхүүнд орсон Ус цаг уурын байгууллагын төлөөлөгч, давтан сургалтад оролцох болон судалгаа нислэг хийж буй синоптик инженерүүдийн онгоцоор зорчих зардлын асуудлыг шийдвэрлэх талаар дэмжлэг үзүүлнэ;

Г) Үйлчлэгч байгууллагын ээлж хамт олон, ажилтнуудын буруутай үйл ажиллагаанаас хэрэглэгч байгууллагад хүндрэл учирсан, саатал зөрчил гарсан, давтан гаргасан нь тогтоогдсон тохиолдолд хариуцлагын арга хэмжээг хэрхэн авах талаар тус тус тусгана;

Д) Агаарын тээвэрлэгч байгууллагууд цаг агаарын мэдээ, мэдээлэл авахгүйгээр агаарын хөлгөөр нислэг үйлдэхгүй байх,

1.10 Нислэгийг цаг агаарын мэдээгээр үйлчлэх, хэрэглэх асуудлаар Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ОУИНБ) болон Дэлхийн цаг уурын байгууллага (ДЦУБ)-ын хурал, зөвлөгөөнд оролцохдоо Монгол Улсын нийтлэг эрх ашигт нийцүүлэн нэгдмэл байр сууринаас хандаж байна;

1.11 Нислэгийн цаг агаарын VOLMET (Нислэг үйлдэж буй агаарын хөлөгт зориулсан цаг агаарын мэдээ) хэлбэрийн мэдээг бэлтгэж, радио нэвтрүүлгээр тусгайлан нэвтрүүлэх ажлыг хоёр тал хамтран хийнэ.

ХОЁР. Иргэний нисэхийн ерөнхий газрын хүлээх үүрэг

2.1 Нислэгийн цаг агаарын үйлчилгээнд мөрдөгдөж буй баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт тавих;

2.2 Нислэгийн цаг агаарын мэдээний талаар Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ОУИНБ)-с ирсэн холбогдох бичиг баримт, шийдвэрүүдийг үйлчлэгч байгууллагад тухай бүр албан тоотоор хүргүүлж байх;

ХЯНАВ

2.3 Шинжилгээ судалгааны ажилд шаардлагатай агаарын зам, нисэх буудал орчмын физик газар зүйн тодорхойлолт болон агаарын хөлгүүдийн нислэг, техникийн үзүүлэлтүүдийг мэдээгээр үйлчлэгч байгууллагын хүсэлтээр албан ёсоор гаргаж өгөх;

2.4 "Нислэгийн мэдээллийн эмхэтгэл" болон нислэг хөдөлгөөний үйлчилгээний журам, зааварт нэмэлт өөрчлөлт орсон тухай бүрд үйлчлэгч талд мэдээлж, шинээр хэвлэгдэх тохиолдолд мэдээгээр үйлчлэгч байгууллагад өгч байх;

2.5 Иргэний нисэхийн чиглэлээр нислэгийн аюулгүй ажиллагаатай холбоотой цаг уурын хурал, семинар, сургалтад үйлчлэгч байгууллагын мэргэжилтнүүдийг оролцуулахад санхүүгийн боломжит дэмжлэг үзүүлэх;

2.6 ИНЕГ-ын Нисэхийн сургалтын төвд зохион байгуулагдах тусгай сургалтанд хамрагдахад санхүүгийн боломжит дэмжлэг үзүүлэх;

2.7 Орон нутагт нислэгийг цаг агаарын мэдээгээр үйлчлэх ажлыг дагнан хийж, нисэх буудал дээр байрлан ажиллаж буй үйлчлэгч байгууллагын ажилтнуудыг эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын нөхцөлд тохирсон ажлын байр, унаа, дулаан, цахилгаан, холбооны суваг, шаардагдах тоног төхөөрөмжөөр хангаж ажилтнуудыг ажилдаа ирэх, буцахад нь байгууллагын ажилчдын унаагаар, аэродромын бүсэд технологийн унаагаар тус тус үнэ төлбөргүй үйлчилнэ.

2.8 Ус, цаг уурын холбооны системд техникийн саатал, сувгийн гэмтэл гарсан тохиолдолд орон нутгийн нислэгт зориулсан цаг агаарын мэдээллийг нисэхийн холбоогоор дамжуулах ба хүлээн авах нөхцлөөр хангах;

2.9 Цахилгаан холбоо төрийн өмчит хувьцаат компани хүртэлх өөрийн байгууллагын шилэн кабелийн сүлжээний хурдыг нэмэгдүүлэх талаар хамтарч ажиллах;

2.10 Нислэгийн цаг уурын төвийг технологийн болон AFTN сүлжээгээр холбох, нислэгт шаардлагатай бодит болон урьдчилсан мэдээг дамжуулах, хүлээн авах, техникийн бололцоогоор хангах;

2.11 Нисэх буудал дээр (аэродромын ажлын байр болон хашаан дотор) байрлаж нислэгийн цаг уурын ажиглалтыг дагнан хийж буй мэдээгээр үйлчлэгч байгууллагын цаг уурын хэмжлийн багаж төхөөрөмжийн харуул, хамгаалалтыг нисэх буудлын харуулд хариуцуулах;

2.12 Нислэгийн цаг агаарын мэдээний үйлчилгээнд шаардлагатай дараах багаж төхөөрөмжөөр хангах бөгөөд тоног төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг хариуцна. Үүнд:

А) Цаг уурын байгууллагаас зайтай оршдог төрийн өмчийн нисэх буудлын цаг агаарын бодит мэдээний хангалтад ашиглах автомат станц;

Б) Нийтийн хэрэгцээний цаг уурын мэдээнд ашиглагдаггүй боловч нэвхэн нислэгийн цаг уур үйлчилгээнд ашигладаг багаж, тоног төхөөрөмжөөр нислэгийн үйлчилгээг дагнан хийдэг Нислэгийн цаг уурын төвийг хангах;

В) Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцийн хавсралт 14-ийн 5.5, ДОК 9328-ын 10.4-д заасан зөвлөмжийн дагуу хөөрч буух зурвасын дагуу алсын барааны харагдацыг тодорхойлох өдөр, шөнийн тэмдэгтээр хангах;

2.13 Хамтын ажиллагааны хүрээнд үйлчлэгч талын албан хаагчдын ажлын үр дүнг харгалзан шагнал урамшилд хамруулах.

ИНЕГ ХЯНАВ

ГУРАВ. Цаг уур, орчны шинжилгээний газрын хүлээх үүрэг

3.1 Монгол Улсын нутагт нислэг үйлдэж буй дотоод, гадаадын агаарын хөлгийн нисэх баг болон тэдгээрт нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлж буй байгууллагыг Дэлхийн цаг уурын байгууллага (ДЦУБ), Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ОУИНБ)-ын шаардлага, стандарт болон "Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах журам"-ын дагуу нислэгийн цаг уурын шуурхай мэдээ, мэдээллээр тасралтгүй үйлчлэх ажлыг зохион байгуулах;

3.2 Нислэгийг цаг агаарын мэдээгээр хангах ажлыг гардан гүйцэтгэж буй Ус цаг уурын байгууллагыг мэргэжлийн боловсон хүчин, ус цаг уурын хяналт шинжилгээнд ашиглах шаардлагатай хэмжлийн багаж төхөөрөмж, арга зүйгээр хангах;

3.3 Нислэгийн цаг агаарын мэдээний чанарыг дээшлүүлэх, шуурхай байдлыг хангах үүднээс нислэгт аюултай цаг агаарын үзэгдлүүдийг ажиглах, урьдчилан мэдээлэх арга зүй боловсруулах чиглэлээр шинжилгээ, судалгааны ажлыг Нислэгийн цаг уурын төвийн (НЦУТ)-ийн төлөвлөгөөнд жил бүр тусган хийлгэж, үйлдвэрлэлд нэвтрүүлж байх;

3.4 Нислэгийн цаг уурын мэдээг хэрэглэгч байгууллагын ажилтнуудын цаг уурын мэдлэгийг дээшлүүлэх сургалт явуулах, мэргэжлийн шалгалт авах, дадлагын ажилд мэргэжлийн туслалцаа үзүүлэх;

3.5 Нислэгийг цаг агаарын мэдээгээр үйлчлэх ажлыг хийж буй синоптик инженерүүдийг 2 жил тутам давтан сургалтад хамруулах;

3.6 Нислэгийн цаг агаарын мэдээний үйлчилгээний талаар Дэлхийн цаг уурын байгууллага (ДЦУБ)-аас ирсэн холбогдох бичиг баримт, шийдвэрүүдийг хэрэглэгч байгууллагад тухай бүр албан тоотоор хүргүүлж байх;

3.7 Нислэгийн төлөвлөлт, шинжилгээ судалгаа, туршилтын ажил болон тайлан, тодорхойлолтод шаардлагатай цаг уурын мэдээ, мэдээллийг тэдний захиалгын дагуу гаргаж өгөх;

3.8 Хэрэглэгч байгууллагын хүсэлтээр нисэх буудлын уур амьсгалын тодорхойлолт, цаг агаарын төлөв байдлын мэдээ гаргаж өгөх;

3.9 Агаарын шинэ зам, нисэх буудал нээх, цаг агаарын хязгаарлал тогтоох, хамтарсан шалгалт хийх, нислэгийн саатал, осол, зөрчлийн шалтгааныг тогтоох комиссын бүрэлдэхүүнд өөрийн мэргэжилтнийг оролцуулж, шаардагдах мэдээ, дүгнэлтийг гаргаж өгөх;

3.10 Мэдээгээр үйлчлэгч байгууллага Нислэгийн цаг уурын төв (НЦУТ), орон нутгийн Ус цаг уурын орчны шинжилгээний газрууд (УЦУОШГ)-ын нислэгийн цаг агаарын мэдээний үйлчилгээний ажлын тайланг жил бүр нэгтгэн гаргаж, Иргэний нисэхийн ерөнхий газарт хүргүүлэх;

3.11 Нислэгийн цаг уурын холбогдолтой заавар, журам, код зэргийг шинэчлэхдээ мэдээ хэрэглэгч талын саналыг албан ёсоор авах ба шинээр хэвлэх бүрдээ мэдээг хэрэглэгч байгууллагад өгч байх;

3.12 Нислэгийн цаг уурын төв (НЦУТ) нь орон нутгийн нислэгт үйлчилдэг цаг уурын байгууллагуудын үйл ажиллагааг мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангаж, ажил үйлчилгээнд нь чанарын хяналтыг тавьж ажиллах;

3.13 Нислэгийг цаг агаарын мэдээгээр үйлчлэгч байгууллагын ажилтнуудын мэргэшлийн зэргийг мөрдөж буй журмын дагуу тогтоох;

3.14 Нислэгийг цаг агаарын мэдээгээр үйлчлэх ажлыг дагнан хийдэг Нислэгийн цаг уурын төвийн ажилтнууд болон орон нутагт энэ ажлыг хавсран хийдэг

ИНЕГ
ХЯНАВ

синоптик инженер, цаг уурын бодит мэдээний үйлчилгээ хийж буй цаг уурын өртөө, харуулын ажиглагч, техникч нарт ажлын үр дүнг харгалзан сарын үндсэн цалингийн 40 хүртэл хувиар сар бүр урамшил олгох;

3.15 Төв орон нутгийн нисэх буудлуудын сар бүрийн хур тунадасны хэмжээ, салхины чиглэл, хурд, хэрс, агаарын температурын мэдээг Нисэх буудлуудын бодлого, зохицуулалтын газарт улирал бүр хүргүүлэх;

3.16 ИНЕГ-ын хариуцан ажилладаг нислэгийн цаг агаарын мэдээний үйлчилгээнд ашиглагдаж байгаа автомат станц, тоног төхөөрөмжүүдэд гэмтэл саатал гарсан тохиолдолд цаг агаарын бодит мэдээгээр тасралтгүй хангах үүднээс баталгаажсан өөрийн автомат станц болон тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангаж ажиллах.

## ДӨРӨВ. Хяналт, хариуцлага

4.1 Хоёр байгууллагын хооронд маргаантай асуудал гарвал зөвшилцлийн замаар шийдвэрлэнэ;

4.2 Мэдээгээр үйлчлэгч, Мэдээ хэрэглэгч байгууллагууд нь гэрээгээр хүлээсэн үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй бол хамтарсан ажлын хэсэг үйлчлэгч, хэрэглэгч байгууллагын удирдлагад албан шаардлага хүргүүлнэ;

4.3 Нислэгийн саатал, зөрчил нь цаг агаарын мэдээний хангалтаас шалтгаалсан бол хариуцлагыг мэдээгээр үйлчлэгч байгууллага, мэдээний ашиглалтаас шалтгаалсан бол мэдээ хэрэглэгч байгууллага тус тус хүлээнэ. Шаардлагатай гэж үзвэл асуудлыг хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлж болно.

## ТАВ. Нислэгийн саатал, осол, зөрчлийн шалтгааныг бүртгэх

5.1 Цаг агаарын байдлаас шалтгаалан гарсан нислэгийн саатал зөрчлийн бүртгэлийг мэдээгээр үйлчлэгч, мэдээ хэрэглэгч хоёр тал тус тусдаа хөтөлж сар, улирлаар нэгтгэн гаргаж үйлчлэгч болон хэрэглэгч байгууллагуудад танилцуулна;

5.2 Мэдээ хэрэглэгч байгууллага нислэгийн осол, зөрчил гарсан тухайд нь ээлжийн синоптик инженер болон мэдээгээр үйлчлэгч байгууллагад шуурхай мэдэгдэнэ;

5.3 Байгууллагууд нислэгийн саатал, осол, зөрчилд дүгнэлт хийж, цаашид давтан гарахаас урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг хамтран хэрэгжүүлнэ.

## ЗУРГАА. Ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар

6.1. Талууд энэхүү гэрээг байгуулахад ашиг сонирхолын зөрчилтэй эсэх талаараа доорх заалтын дагуу мэдэгдэнэ.

6.1.1. Үйлчлэгч байгууллага энэхүү гэрээг байгуулахад Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан сонирхолын зөрчилтэй эсэх;

Тийм Үгүй

\доогуур зурна уу/

6.1.2. Хэрэглэгч байгууллага энэхүү гэрээг байгуулахад Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах,

ИНЕГ ХЯНАВ

сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан сонирхолын зөрчилтэй эсэх:

Тийм Үгүй

/доогуур зурна уу/

6.2. Ашиг сонирхлын зөрчилтэй эсэх асуулгад тийм гэж хариулсан тохиолдолд энэхүү гэрээ байгуулах үйл ажиллагаа дуусгавар болно.

6.3. Уг асуулгад үгүй гэж хариулсан боловч ашиг сонирхлын зөрчилтэй болох нь тогтоогдсон тохиолдолд гэрээ хүчингүй болж, гэрээ байгуулахад оролцсон бүх этгээдүүд хуульд заасан хариуцлага хүлээнэ.

ДОЛОО. Гэрээний хугацаа, гэрээ хүчин төгөлдөр болох

7.1. Хоёр тал гарын үсэг зурж, тамга дарснаар энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох ба 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.

7.2. Энэхүү ерөнхий гэрээний хугацаа дуусахад хоёр тал гэрээг дүгнэн цаашид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзвэл 1 жилээр сунгагдсанд тооцно.

7.3. Дээрх хугацаанд ерөнхий гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал гарвал хоёр талын хамтарсан ажлын хэсэг хурлаараа хэлэлцэн ерөнхий гэрээг шинэчлэн боловсруулах эсхүл нэмэлт өөрчлөлт оруулж болно.

xxXXxx

| "Мэдээ хэрэглэгч" талыг төлөөлөн: | "Мэдээгээр үйлчлэгч" талыг төлөөлөн: |
|---|---|
| АГААРЫН НАВИГАЦИ, НИСЭХ БУУДЛЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА | ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА |
| Д.ЭРДЭНЭБААТАР | Б.БАТТУЛГА |
| САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА | НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ТӨВИЙН ДАРГА |
| Ч.НЯМСҮРЭН | Б.БАНЬДСҮРЭН |
| ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ, ДҮРМИЙН БОЛОВСРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА | САНХҮҮ, ТӨЛӨВЛӨЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА |
| П.АРИУНБОЛД | Б.ЭРДЭНЭМӨНХ |

ХЯНАВ